

*Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооны саналаар хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан*

**Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зориулалтаар олгосон
зээлийн хэрэгжилтийн байдал**



**Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зориулалтаар
олгогдсон зээлийг зарим аж ахуйн нэгж, иргэд
зориулалт бусаар ашиглаж байна**

2011 он

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</p> <p>Захирал Д. Ганбилэг</p> <p>Аудитын менежер Х.Баярмаа</p> <p>Ахлах аудитор Г.Цэдэнбалжир</p> <p>Шинжээч Ц.Цолмон Ш.Энхтайван Н.Саруул Б.Болормаа Т.Батзориг</p> <p>2011 оны 09 дүгээр сар</p> <p>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</p> <p>www.mnao.mn</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 262451, 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу</p> <p><u>ХАЯГ: Үндэсний аудитын газар</u> Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр Улаанбаатар хот 15160 Монгол улс</p>	Товчилсон үгийн тайлбар	2
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	3
	Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл.....	4
	Бүлэг 1 Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр ажиллаж буй нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт оновчтой бус, хууль эрх зүйн актын зарим заалт зөрчилтэй байна	
	• Ерөнхий зүйл	5
	• Хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай байна	8
	• Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчин боловсронгуй бус байна	9
	• Төслийг сонгон шалгаруулах комисс үйл ажиллагааны журмаа биелүүлэхгүй байна	10
	• Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт зохих журмын дагуу хийгдэж байна	12
	Бүлэг 2 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхээр олгосон зээлийг зарим аж ахуйн нэгж, байгууллага зориулалтын дагуу зарцуулахгүй байна.	
	• Төсөл сонгон шалгаруулах комиссын шийдвэрийг үндэслэн ЖДҮХС-аас арилжааны банкуудаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээлийг зарим аж ахуйн нэгж зориулалтын дагуу ашиглахгүй байна	15
	• Төслийг хэрэгжүүлснээр тухайн нэгжид ажлын байр болон төсвийн орлого нэмэгдэж байгаа нь баримтаар бүрэн нотлогдохгүй байна	22
	Дүгнэлт.....	25
	Зөвлөмж.....	26
	Холбогдох байгууллагын санал:	27
Саналд өгсөн тайлбар	33	
Хавсралт	34	
Ерөнхий аудиторын тушаал	43	

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГ	Засгийн газар
СЯ	Сангийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЖДҮДТ	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХААЖДҮГ	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ААН	Аж ахуйн нэгж
ТАТХ	Төрийн аудитын тухай хууль
ЖДҮТХ	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль
ТСШК	Төсөл сонгон шалгаруулах комисс
ТСШДК	Төсөл сонгон шалгаруулах дэд комисс
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим
ТББ	Төрийн бус байгууллага
ГТХАН	Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ҮҮХ	Үйлдвэр үйлчилгээний хэлтэс
ОУХАБ	Олон улсын хамтын ажиллагааны байгууллага
СТБЗГ	Стратеги төлөвлөлт, бодлого зохицуулалтын газар
ХҮХҮБХГ	Хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийн газар
ХҮБХГ	Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн газар
ТЗУГ	Төрийн захиргааны удирдлагын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооноос ирүүлсэн санал, Монгол Улсын Ерөнхий аудитор Т Үндэсний аудитын газраас 2011 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

2009, 2010 онд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг үнэлж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээлийн бодлого үр нөлөөтэй эсэх,
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхээр олгосон зээл үр нөлөөтэй эсэх

Хамарсан хүрээ

Аудитад ЖДҮХС-гийн 2009, 2010 оны үйл ажиллагаа, ХХААХҮЯ, Жижиг, дунд үйлдвэрийн газар, арилжааны "Төрийн", "Капитрон", "Голомт", "Хас", "Улаанбаатар", "Худалдаа хөгжил", "Хаан", "Хадгаламж", "Үндэсний хөрөнгө оруулалтын" банк, "Хас лизинг" ХХК, "Эн ви си" ХХК болон зээл авч ашиглаж буй зарим аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, зээлдэгч нарыг хамрууллаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах;
- Хамрагдсан байгууллагуудын ажлын тайлан, төслийн сонгон шалгаруулалтын явц болон хөрөнгийн зарцуулалт, тайлагнал, цуглуулсан мэдээ, судалгаанд холбогдох асуудлаар дүн шинжилгээ хийх;
- ЖДҮДС, арилжааны банк, зээлдэгч нарын хооронд байгуулсан гэрээ, гүйцэтгэлийг түүвэрлэн шалгах;

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл

Аудитын явцад зарим арилжааны банк (ХААН, Хас банк) ЖДҮХС-гийн хөрөнгийг дамжуулан олгосон мэдээлэл (зээл авсан аж ахуйн нэгж, иргэдийн хаяг, байршил, утасны дугаар) гаргаж өгөхөөс татгалзах, чирэгдэл учруулах, хагас дутуу материал өгөх, үнэн зөв гаргахгүй байх, ЖДҮ, бизнес эрхлэгчид санхүүгийн тайлан үзүүлэхгүй, техник, тоног төхөөрөмжийг худалдан авсан анхан шатны баримт, ашиглалтын талаар тайлбар өгөхөөс татгалзах, оршин суух болон үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй хаягаа хэлэхгүй, зарим нь өөрсдийн хөрөнгийг барьцаалж арилжааны банк буюу ЖДҮХС-гаас зээл авсан учир аудитын байгууллагад хамаагүй гэсэн тайлбар өгч аудитын ажилд саад учруулж байсан болно.

Бүлэг 1

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр ажиллаж буй нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт оновчтой бус, хууль эрх зүйн актын зарим заалт зөрчилтэй байна

Ерөнхий зүйл

1.1 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйл ажиллагааг ХХААХҮЯ-ны газар, хэлтсүүд, ЖДҮГ, ЖДҮХС, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дэргэдэх холбогдох хэлтэс хэрэгжүүлж байна.

1.2 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГ нь “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийн дагуу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд төрийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох, тэдний эрх ашигт нийцсэн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, төрийн захиргааны удирдлага зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд дараахь чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлж байна:

- Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх;
- Шинэ, дэвшилт техник технологийг нутагшуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Тэргүүлэх чиглэлийн үйлдвэрүүдийг татвар, гааль, санхүүгийн бодлогоор дэмжих;
- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын аж ахуйн нэгжүүдтэй холбож өгөх;
- Шинэ тэргүүний тоног төхөөрөмжийн судалгаа хийх, сонголт хийхэд нь туслалцаа үзүүлэх;
- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн менежментийн үндэс суурийг бэхжүүлэх, эрсдлээс хамгаалах тогтолцоо бий болгох;
- Шинжлэх ухааны байгууллагуудын уялдаа холбоог бий болгон, сургалт зохион байгуулах;
- Мэдээллийн санг байгуулж эрхлэн хөтлөх.

1.3 ЖДҮХС нь ХХААХҮЯ-нд харьяалагдаж, “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” болон “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн дагуу дараахь чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлж байна:

- ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж ажлын байр бий болгох;
- ЖДҮ эрхлэгчдэд тоног төхөөрөмжийг лизингээр олгох механизмыг бий болгох;
- Зах зээлийн харилцаанд зохицсон сургалт зохион байгуулах замаар ЖДҮ эрхлэгчдэд үйл ажиллагааны менежментийн чадавхийг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

1.4 ХХААХҮС-ын тушаалаар “Жижиг, дунд үйлдвэрийн газрын дүрэм”¹, “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн дүрэм” болон “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг² баталжээ.

¹ 2009 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 19 дүгээр тушаал

² 2009 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 29 дүгээр тушаал

1.5 Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль, ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Үйлдвэр, худалдааны сайдын (хуучнаар) шийдвэрээр 2008 онд Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг, Дархан-Уул, Завхан, Говь-Алтай аймгуудад Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвүүдийг нээн ажиллуулж, улмаар ХХААХҮЯ-ны ЖДҮГ-ын бүтцэд хамааруулсан байна.

1.6 Дээрх төвүүдийн зорилго нь "Жижиг, дунд үйлдвэрийн тухай" хууль, ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрийн дагуу зах зээлд бие даан хөгжих чадвартай ААН-ийг бойжуулж, тэдний бизнесийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, бизнес инкубацийн үйлчилгээ, зөвлөгөө, мэдээллээр хангах, мэргэжлийн сургалт явуулахад чиглэсэн байна.

1.7 ЖДҮГ, ЖДҮХС, ЖДҮДТ-үүдийн дүрмээр тодорхойлсон үйл ажиллагааны зорилго, ЖДҮ, бизнес эрхлэгч нарт үзүүлж буй үйлчилгээг схемээр үзүүлбэл:



1.8 Зургаас харахад ЖДҮГ, ЖДҮХС, ЖДҮДТ-дийн иргэд, ААН-үүдэд үзүүлж буй үйлчилгээнүүд давхардаж байгаа бөгөөд тус тусдаа бие даан ажиллаж байна. Тухайлбал:

- ЖДҮХС нь ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл, санхүүгийн түрээс буюу тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээг арилжааны банк, ББСБ-аар дамжуулан хүргэх, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг дагнан гүйцэтгэж, зээл олголт болон хэрэгжилтийн хяналтыг ХХААХҮЯ, ЖДҮГ-тай хамтран хэрэгжүүлж байна.
- ЖДҮГ нь ЖДҮ-ийн салбарын эрх зүйн орчинг сайжруулах талаар судалгаа хийж, санал боловсруулан холбогдох газруудад хүргүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох, судалгаа хийх, үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах, МХАҮТ, мэргэжлийн холбоо, ТББ, гадаад дотоодын бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, төрийн захиргааны удирдлага зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх үүргийг дагнан хэрэгжүүлж зээл олголт, мэдээллийн сан, хэрэгжилтийн хяналтыг ХХААХҮЯ, ЖДҮХС, орон нутгийн ХХААЖДҮГ-тай хамтран хэрэгжүүлж байна.

1.9 ЖДҮДТ-үүд ХЭДС-аас зарласан сургалт явуулах тендерт оролцож тодорхой санхүүжилтийг авч үйл ажиллагаа, бизнес инкубацийн үйлчилгээ эрхэлж байгаа боловч жижиг, дунд бизнес эрхлэгч нарт зориулсан сургалт, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах ажил хангалттай түвшинд хийгдэхгүй байна. Тухайлбал 2010 онд ЖДҮДТ-дэд 150 гаруй ААН бойжиж 9816 иргэн бизнесийн зөвлөгөө үйлчилгээ авсан³ байна.

1.10 ЖДҮХС-аас банкуудтай байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-нд зээлийн зориулалтаар гаргаж байгаа банкинд байршуулсан санхүүжилтээс сарын 0.1 хувиар хяналтын зардал, сургалт зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд зарцуулахаар улирлаар тооцон тус санд нэхэмжлэлийн дагуу төвлөрүүлж байгаа боловч уг хөрөнгөөс Бизнес инкубатор төвүүдэд олгогдоогүй байна.

1.11 ЖДҮХС-ийн үндсэн зорилгод “... сургалт явуулах” гэж заасан байгаа ч энэ нь гарын авлага, загвар төслүүдийг худалдан борлуулахаас хэтрэхгүй байна. Тухайлбал 2010 онд сан 385 бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгч 2385 гарын авлагыг олны хүртээл⁴ болгожээ.

1.12 ЖДҮГ, ЖДҮХС нь олон нийтэд төрийн үйлчилгээг нээлттэй түргэн шуурхай хүргэх, мэдээлэх зорилгоор www.sme.gov.mn, www.smefund.mn гэсэн сайтуудыг эрхлэн ажиллуулдаг боловч тэнд байгаа мэдээллийг цаг тухайд нь шинэчлээгүй байна.

1.13 ЖДҮХС бүс нутгийн эдийн засгийн хөгжилд тодорхой нэмэр болох төслийг хүлээн авч, судалж, дүн шинжилгээ хийн ТСШК-ын хуралдаанд оруулдаг бол аймгийн ХХААЖДҮГ, нийслэлийн Үйлдвэрлэлийн хэлтэс орон нутгийн төслийг хүлээн авч, судалж, дүн шинжилгээ хийн ТСШДК-ын хуралдаанд оруулж шийдвэр гаргуулдаг байна.

1.14 ЖДҮ-ийг хөгжүүлэхдээ зөвхөн төсөл хүлээн авч сонгон шалгаруулж, зээл олгох бус тодорхой бодлого боловсруулан үе шатаар хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1.15 Хөгжлийн жишээ болохуйц Солонгос улсын Жижиг, дунд бизнесийн корпорацийн үйл ажиллагааны чиглэлүүдийг хүснэгтээр үзүүлэв.

Санхүүжилтийн үйл ажиллагаа	Эрсдэлтэй бизнесийг эхлүүлэх
	Судалгаа шинжилгээний үйл ажиллагааг үйлдвэрлэлд нэвтрүүлэх
	Хөгжлийн шинэ үйлдвэрлэлийг дэмжих
	Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих программ
	Удирдлагын тогтворжуулалт
	Бизнесийг өөрчлөх
	Худалдааг дэмжих
	Авлага болон капиталын солилцоо
	Бизнес үүр
	Бизнесийн хамтын ажиллагаа
Зөвлөгөө өгөх үйл ажиллагаа	Бизнес шинэчлэл
	Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
	Корпорацын шинжилгээ
	Шинэ санааг үйлдвэрлэлд нэвтрүүлэх
	Маркетинг ба сурталчилгаагаар хангах
Сургалт явуулах	Жижиг, дунд бизнесийн сургалтын институт
Гадаад маркетингийн үйл ажиллагаа	Гадаад дахь үзэсгэлэн
	Худалдааны төлөөлөгч

³ ЖДҮГ-ын 2010 оны ажлын товч тайлан

⁴ ЖДҮХС-ийн 2010 оны үйл ажиллагааны тайлан

Нэг нэгээр нь холбох
Гадаад дахь зах зээлийн судалгаа
Гадаад дахь салбар
Бизнес аялал зохион байгуулах
Экспортыг дэмжих программ
Гадаадын зөвлөх компаниудаар үйлчилгээ үзүүлэх
Худалдааны мэргэжилтнүүдийн сургалт
Экспортын инкубатор
Брандын хөгжүүлэлтийн үйлчилгээ

1.16 “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуульд ЖДҮХС-гийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг Засгийн газар тогтоохоор заасан атал ХХААХҮС-ын тушаалаар⁵ тогтоож байна. УИХ-ын 2007 оны 52 дугаар тогтоолын 1.2-т “Үйлдвэр, худалдааны яам болон холбогдох бусад төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр ажиллаж байгаа хэлтэс, алба, сан, төслийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлагийн бүтцэд шилжүүлэх”-ээр заасан боловч ЖДҮХС нь ХХААХҮЯ-ны бүтцийн нэгж хэлбэрээр ажиллаж, өмнөх аудитаар илэрсэн дээрх зөрчил дутагдал арилаагүй байна.

1.17 Энэ бүгдээс үзэхэд ЖДҮГ, ЖДҮХС, Бизнес инкубатор төвүүд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр ижил төстэй чиг үүрэгтэй ч тус тусдаа бие даан ажиллаж байна. Энэ нь үйл ажиллагааны давхардал бий болгох, хөрөнгө мөнгө үргүй зарцуулагдах нөхцлийг бий болгож байна.

Хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай байна

1.18 ЖДҮ-ийг хөгжүүлэх зорилгоор ЖДҮХС улсын төсвөөс 2009 онд 30.8 тэрбум, 2010 онд 30 тэрбум, нийт 60.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авснаас арилжааны банкуудаар дамжуулан (эргэн төлөлт оролцуулан) нийт 66.2 тэрбум төгрөгийн зээл олгож, 11.5 тэрбум төгрөгийн зээл төлөгдөж, 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 57.9 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.

1.19 Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрөөс гадна чиглэлийн хувьд давхардахуйц дараахь хөтөлбөрүүд хэрэгжиж, тэдгээрийг ХХААХҮС-ын 2010 оны төсвийн багцын төвлөрсөн арга хэмжээний зардал болон холбогдох сангуудаас доорхи дүнгээр санхүүжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

		(сая төгрөгөөр)	
№	Хөтөлбөрийн нэр	Хугацаа	2010 оны дүн
1	“Малын чанар сайжруулах” хөтөлбөр		323,0
2	“Эрчимжсэн МАА-н хөгжлийг дэмжих” хөтөлбөр		1'220,1
3	“Цаа буга” хөтөлбөр		90,9
4	“Малын тэжээл” хөтөлбөр		421,6
5	“Экологийн цэвэр бүтээгдэхүүн” хөтөлбөр		19,1
6	“Хэвлэлийн үйлдвэрлэл” хөтөлбөр		19,6
7	“Ноос” дэд хөтөлбөр		50,0
8	“Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөр		35,0
9	“Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих” хөтөлбөр		50,0
10	“Мод боловсруулах”		35,0
11	Арьс шир		38,5
12	Хоршоо хөтөлбөр		46,0
13	Чацаргана хөтөлбөр		932,1
14	Сүү хөтөлбөр		450,0
	Нийт дүн		3'728,7

⁵ ХХААХҮС-ын 2009 оны 1, 49 дүгээр тушаал

1.20 Эдгээр хөтөлбөрийн хүрээнд ЖДҮ-ийн тухай хуулиар тодорхойлсон жижиг, дунд үйлдвэрлэгчдийн ангилалд багтсан ААН, иргэдэд зээл олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, сургалт, судалгаа, сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх зэрэг ЖДҮГ, ЖДҮХС, ЖДҮДТ-үүдийн үйл ажиллагаанд хамаарах үйл ажиллагаа хийгдэж байна.

1.21 Иймд тус яамны ижил төстэй хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчин боловсронгуй бус байна

1.22 “Жижиг дунд үйлдвэрийн тухай”, “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулиуд, ЗГ-ын тогтоол, шийдвэрийг үндэслэж дараахь журам зааврыг шинэчлэн баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан, бүртгүүлж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тухайлбал,

- ХХААХҮС-ын 2009 оны 107 тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан зээл олгох төслийг сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагааны журам”-ыг мөн сайдын 2010 оны 35 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан;
- ХХААХҮС-ын 2009 оны 147 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр улсын төсвөөс олгох хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах заавар”-т нэмэлт, өөрчлөлт оруулж, 2010 оны 58 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан;
- Арилжааны банкуудаар хөнгөлөлттэй зээлийг дамжуулан олгох, хамтран ажиллах гэрээг шинэчлэн боловсруулж, нэмэлт гэрээг 2010 онд байгуулсан;
- “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүгийн түрээс /лизинг/-ийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдтэй хамтран ажиллахад мөрдөх журам”-ыг боловсруулан ХХААХҮС-ын 2010 оны А/184 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлуулж, мөрдөн ажиллаж байна.

1.23 Зарим хууль эрх зүйн актууд өнөөгийн шаардлагад нийцэхгүй, давхардал болон зөрчил, хийдэл үүсгэж байна. ЖДҮ-ийг цаашид үр дүнтэй, тогтвортой хөгжүүлэхэд дараахь хууль эрх зүйн орчинг өөрчлөн сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

- Үйлдвэрлэгчид өөрийн хөрөнгө байхгүй буюу дутмаг, хүссэн зээлээ авч чаддаггүйгээс ихэнх тохиолдолд зээлийг зориулалт бусаар ашиглах явдал гарч байна. Иймд “Зээлийн батлан даалтын тухай хууль” шинээр гаргах;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5-д “баталгаа гаргах” гэж заасан нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуультай зөрчилдөж байгааг эргэж харах;
- ЖДҮТХ-ийн ЖДҮ дэмжих төрийн үйлчилгээнд охин компани оролцох үед толгой компанийн холбогдох үзүүлэлтийг хамааруулан тооцох тухай заалтыг нэмж оруулах;

1.24 ЖДҮТХ-ийн 5 дугаар зүйлд⁶ ЖДҮ эрхлэгчийн ангиллыг тодорхойлсноор гэрээгээр 199 хүртэлх ажиллагсадтай, жилийн борлуулалтын орлого нь 250,0-1500,0 сая төгрөг, аж ахуйн хэлбэр нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд хамаарагдахаар заасан нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэн болон хуулийн этгээд бараг бүгд хамрагдахаар байна.

Олон улсын жишээ

Европын холбооны бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн тодорхойлолтыг хүснэгтээр үзүүлэхэд:

Төрөл	Ажиллагсдын тоо	Борлуулалт	Хөрөнгийн дүн
Дунд	250-иас ихгүй	50 сая еврогоос ихгүй	43 сая еврогоос ихгүй
Жижиг	50-иас ихгүй	10 сая еврогоос ихгүй	10 сая еврогоос ихгүй
Бичил	10-аас ихгүй	2 сая еврогоос ихгүй	2 сая еврогоос ихгүй

Европын холбоо нь бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дээрх аргачлалаар тодорхойлохоос гадна өмчлөлийн хувь хэмжээгээр нь тухайн ААН-ийг бусад ААН-ээс хэр хамааралтайг нь тодорхойлдог байна.

БНСУ-ын хувьд Жижиг, дунд ААН, жижиг бизнес, микро нэгж гэж ангилдаг ба үйлдвэр, үйлчилгээний салбар бүрээр ажиллагсдын тоо, хөрөнгийн хэмжээг тогтоож өгсөн байна.

Төслийг сонгон шалгаруулах комисс үйл ажиллагааны журмаа биелүүлэхгүй байна

1.25 Хөнгөлөлтэй зээлийн төслийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ХХААХҮС-ын 2010 оны 35, 58 дугаар тушаалаар баталсан журмыг үндэслэж ЖДҮ-ийн зээлийн төслийг тус тус сонгон шалгаруулах комисс явуулж байна.

1.26 Өнөөгийн байдлаар 21 аймаг, нийслэлийн Засаг даргаар ахлуулсан ТСШДК, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ТСШК хөнгөлөлттэй зээлийн төслийг сонгон шалгаруулж, арилжааны банкаар дамжуулан олгож байна.

1.27 ТСШК, ТСШДК хөнгөлөлтэй зээлийн төслийн сонгон шалгаруулалтад дараахь үндсэн шалгуурыг тавьж байна. Үүнд:

- “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд заасан ЖДҮ гэсэн шалгуурыг хангасан байх;
- ЗГ-ын 2009 оны 178 дугаар тогтоолоор баталсан “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл” аймаг, нийслэлийн бодлоготой уялдаж байх;
- тухайн ондоо багтаж ашиглалтад орж үйл ажиллагаагаа эхлэх боломжтой байх.
- ажлын байр шинээр бий болгосон байх;
- эргэн төлөгдөх бололцоотой, зах зээлтэй байх;
- тодорхой хэмжээнд банкны шалгуур дааж, баталгаа хөрөнгөтэй байх.

⁶ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч

1.28 Хэдийгээр ТСШК болон ТСШДК дээрх шалгуурыг харгалзан төслийг шалгаруулдаг боловч тэр бүр журмаа баримтлахгүй байна. Тухайлбал, аймаг, нийслэлийн ХХААЖДҮГ, ҮҮХ-ийн ЖДҮ хариуцсан мэргэжилтэн ХХААХҮС-ын 2010 оны 35 дугаар журмын шаардлага хангасан төслүүдэд зээлийн дүн шинжилгээ судалгааг хийж, дүгнэлт бэлтгэн ТСШДК-ын хуралдаанд оруулах чиг үүрэгтэй ч энэ үүргийг хангалттай биелүүлэхгүй, арилжааны банкны шалгуурт найдан сонгон шалгаруулалтыг хийж байна.

1.29 2009, 2010 онд хийсэн төслийн сонгон шалгаруулалтыг хүснэгтээр харуулбал:

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл сонгон шалгаруулах комиссуудын 2009 оны ажлын үр дүн

Үзүүлэлт	Төслийн санал	ТСШК-ийн дэмжсэн	ТСШК-оос буцаагдсан төсөл	Банкнаас дэмжигдсэн төсөл	Банкнаас буцаагдсан төсөл
Төсөл сонгон шалгаруулах комисс	72	43	29	38	5
Төсөл сонгон шалгаруулах Нийслэлийн дэд комисс	785	739	46	206	533
Дүн	857	782	75	244	538

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл сонгон шалгаруулах комиссуудын 2010 оны ажлын үр дүн

Үзүүлэлт	Төслийн санал	ТСШК-ийн дэмжсэн	ТСШК-оос буцаагдсан төсөл	Банкнаас дэмжигдсэн төсөл	Банкнаас буцаагдсан Төсөл
Төсөл сонгон шалгаруулах комисс	200	101	34	89	12
Төсөл сонгон шалгаруулах Нийслэлийн дэд комисс	861	714	147	143	571
Дүн	1061	815	181	232	583

1.30 Дээрх хүснэгтээс харахад ТСШК-т 2009 онд 857 төслийн санал ирснээс 782 нь дэмжигдэж, 75 төсөл буцаагдаж байсан бол банкнаас 538 төсөл буцаагджээ. Тус комисс 2010 онд 1061 төсөл хүлээн авснаас 815 төсөл дэмжигдэж, банк 583-ыг буцааж, 232 аж ахуйн нэгж байгууллагад зээл олгосон байна.

1.31 Буцаасан зээлийн материалыг судалж үзэхэд зээл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгжийн төслийн үйл ажиллагаа тогтворгүй, барьцаа хөрөнгө хангалтгүй, зээл, зээлийн хүүг бүрэн төлөх чадваргүй, зээлээр худалдаж авах тоног төхөөрөмжийн судалгаа байхгүй, бусад банк санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн болон татварын өртэй, үйл ажиллагааны талаарх мэдээллийг худал ирүүлсэн, арилжааны банкуудад чанаргүй зээлийн түүхтэй, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж өгөөгүй гэсэн голлох шалтгаантай байна.

1.32 ТСШДК нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5.3 "Зээлийн баталгаа гаргах" гэсэн заалт, ХХААХҮС-ын 2009 оны 107 дугаар тушаалаар баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан зээл олгох төслийг сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагааны

журам”-ын 2.13⁷ дахь заалтыг үндэслэж төлбөрийн чадваргүй, барьцаа хөрөнгөгүй зарим аж ахуй нэгжид бодлогын зээл олгожээ.

1.33 Гэвч энэ зээлийг авсан зарим аж ахуйн нэгж (аймаг орон нутгийн Засаг дарга болон ХХААЖДҮГ-ын удирдлага баталгаа гаргаж өгсөн) гэрээнийхээ үүргийг биелүүлээгүйн улмаас дараахь аж ахуйн нэгж, байгууллагуудын зээлийн өрийн төлбөрийг арилжааны Хас, Улаанбаатар, Хадгаламж банкууд ЖДҮХС-гаас суутган тооцсон байна. Үүнд:

○ Эхлэхүүд ХХК	15,894,0	Улаанбаатар банк
○ Энхсэржим ХХК	59,081,9	Хас банк
○ Хаан ембүү ХХК	50,083,6	Хас банк
○ Баянгийн говь ХХК	27,259,1	Хадгаламж банк
○ Хэнтий Оргил ХХК	40,548,2	Улаанбаатар банк
○ Оргил констракшн ХХК	40,074,2	Хас банк
Бүгд	232,940,9	

1.34 Иймд ЖДҮХС-гаас суутган тооцсон 232,9 сая төгрөгийг дээрх нэр бүхий аж ахуйн нэгжээс нэхэмжлэн авч, санг хохиролгүй болгуулах нь зүйтэй гэж үзэв.

1.35 Энэ нь ТСШК болон ТСШДК арилжааны банкаар дамжуулан зээл олгох дэд комиссын үйл ажиллагааны журмын 2.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, төслийг сайтар судлаагүйгээр бодлогын зээлд хамруулсантай холбоотой байна.

1.36 ЖДҮГ, ХХААХҮЯ хамтран орон нутгийн нөөц боломж, хэрэгцээ шаардлага, түүхий эдэд тулгуурласан, орон нутгийн онцлогт тохирсон ЖДҮ-ийг хөгжүүлэх чиглэлээр аймаг, сум бүрээр нарийвчилсан судалгаа хийж ЗГ-аар “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл”⁸-ийг батлуулсан боловч ТСШК, ТСШДК энэ чиглэлийг барьж сонгон шалгаруулалт хийхгүй байна.

Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт зохих журмын дагуу хийгдэж байна

1.37 ЖДҮХС-д 2009 оноос өмнөх жижиг дунд үйлдвэрийг дэмжих зориулалтаар олгосон зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 3170,0 сая төгрөг байсан бол 2009 онд 30'850,0 сая төгрөг, 2010 онд 35'403,4 сая төгрөг, бүгд 66,253,4 сая төгрөгийг нэмж олгосноос 2009 онд 970,0 сая төгрөг, 2010 онд 10,581,3 сая төгрөг, бүгд 11,551,3 сая төгрөг төлөгдөж, 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 57,872,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

1.38 ЖДҮХС-гийн эх үүсвэрийн байршлыг хүснэгтээр харуулбал:

2010 оны 12 сарын 31-ны байдлаар арилжааны банкинд байршиж байгаа эх үүсвэрийн судалгаа								
сая төгрөг								
Д/д	Арилжааны банкны нэр	2009			2010			
		Эхний үлдэгдэл	Гүйлгээ		Эцсийн үлдэгдэл	Гүйлгээ		Эцсийн үлдэгдэл
			нэмэгдсэн	хасагдсан		нэмэгдсэн	хасагдсан	
Орон нутгийн төслийн зээл								

⁷ 2.13 “Шалгаруулах комисс өөрийн эрх мэдлийн хүрээнд МУ-ыг хөгжүүлэх үндэсний цогц бодлого, Мянганы хөгжлийн зорилт, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, ЗГ-аас боловсруулсан үйлдвэржүүлэх хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичигт тусгагдсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээдэд санхүүжилт олгож, дэмжих шаардлагатай гэж үзвэл Бодлогын зээл олгохоор шийдвэр гаргах эрхтэй”

⁸ “орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл” ЗГ-ын 2009 оны 178 дугаар тогтоол

1	Хас	990.0	4,200.0	320.0	4,870.0	3,000.0	1,363.9	6,506.1
2	Монгол шуудан	990.0	3,760.0	320.0	4,430.0	4,500.0	340.0	8,590.0
3	Төрийн	950.0	3,390.0	330.0	4,010.0	2,500.0	3,862.0	2,648.0
4	Улаанбаатар		5,000.0		5,000.0	2,734.9	750.8	6,984.1
5	Капитрон	40.0	2,000.0		2,040.0	2,000.0		4,040.0
6	Голомт				-	1,078.8	78.8	1,000.0
7	ХААН				-	3,000.0	207.8	2,792.2
	Дүн	2,970.0	18,350.0	970.0	20,350.0	18,813.7	6,603.3	32,560.4
Бүс нутгийн эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулах төслийн зээл								
1	ХХБ		2,736.0		2,736.0	3,379.0		6,115.0
2	Капитрон		948.0		948.0	490.0	348.0	1,090.0
3	Голомт		1,736.0		1,736.0	2,629.9		4,365.9
4	Хадгаламж		3,000.0		3,000.0	952.0	1,280.0	2,672.0
		200.0			200.0		200.0	-
5	Төрийн		800.0		800.0		680.0	120.0
6	ХААН		320.0		320.0	2,890.0	750.0	2,460.0
7	ҮХО-н банк		2,800.0		2,800.0	680.0	720.0	2,760.0
8	Улаанбаатар		160.0		160.0	1,085.0		1,245.0
10	Хас				-	2,464.0		2,464.0
	Дүн	200.0	12,500.0	-	12,700.0	14,569.9	3,978.0	23,291.9
Лизингийн зээл								
1	Хас лизинг ХХК				-	1,400.0		1,400.0
2	Эн ви си ХХК				-	600.0		600.0
3	Энхсэржим ХХК				-	3.9		3.9
4	Эхлэхүүд ХХК				-	15.9		15.9
	Дүн	-	-	-	-	2,019.8	-	2,019.8
	Нийт дүн	3,170.0	30,850.0	970.0	33,050.0	35,403.4	10,581.3	57,872.1

1.39 Хөнгөлөлттэй зээлийг дараахь хэлбэрээр олгож байна.

	Орон нутаг	Нийслэл	Бүс нутгийн	Лизинг
Зээлийн хэмжээ	50 сая төг. хүртэл	100 сая төг. хүртэл	500 сая төг. хүртэл	50 ба 100 сая төг. хүртэл
Зээлийн хүү /сарын/	1%	1%	0.8%	0.9%
Хугацаа	3 жил	3 жил	5 жил	4 жил

1.40 Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ЖДҮ-ийн талаар тусгагдсан зорилт, чиглэл болон ХХААХҮЯ-наас явуулсан жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх боломжтой бүс нутгийг тодорхойлсон судалгаанд тулгуурлан “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл батлах тухай” ЗГ-ын 2009 оны 178 дугаар тогтоолыг баримтлан хөнгөлөлттэй зээл олгох ёстой.

1.41 Энэхүү тогтоолын хэрэгжилтийг судалж үзэхэд 2009 онд махны анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрийг Баянхонгор, Говь-Алтай, Дундговь аймгуудад

байгуулах зорилттой атал Голомт банкнаас “Эрдэнэ хүнс само” ХХК-д 1000,0 сая төгрөг (Төв аймгийн Эрдэнэ сум), ХХБ-наас “Баяндулаан-Уул” ХХК-д 1000,0 сая төгрөг (Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум) олгож, махны үйлдвэрүүд баригдсан байна. Мөн түүнчлэн 2011 онд Голомт банкнаас Тайж трейд ХХК-д 1000,0 сая төгрөг (Улаанбаатар хотод) махны үйлдвэр барихаар олгосон байна.

1.42 Харин тогтоолын чиглэлд тусгагдсан Сүү боловсруулах цех болон үйлдвэрийг Баянхонгор, Хөвсгөл, Дорнод, Булган, Дархан–Уул Сэлэнгэ, Төв зэрэг аймагт байгуулаагүй байна.

1.43 Өөрөөр хэлбэл ”Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл батлах тухай” ЗГ-ын 2009 оны 178 дугаар тогтоолын үзэл баримтлал бүрэн хэрэгжээгүй байна.

Бүлэг 2

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхээр олгосон зээлийг зарим аж ахуйн нэгж, байгууллага зориулалтын дагуу зарцуулахгүй байна

Төсөл сонгон шалгаруулах комиссын шийдвэрийг үндэслэн ЖДҮХС-гаас арилжааны банкуудаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээлийг зарим аж ахуйн нэгж зориулалтын дагуу ашиглахгүй байна.

2.1 Комиссуудын сонгон шалгаруулсан төслүүдээс дараахь зөрчил, дутагдлууд илэрлээ. Үүнд:

1.Худалдаа хөгжлийн банк

2.2 ХХБ ЖДҮХС-гийн санхүүжилтээс дараахь аж ахуйн нэгж, байгууллагад зээл олгожээ. Тухайлбал,

- “Гачуурт” ХХК 2000 тн хүнсний ногооны агуулах барихаар 1000,0 сая төгрөг
- “Баяндулаан-Уул” ХХК Мал нядлах, мах ангилан боловсруулах үйлдвэр барих зориулалтаар 1000,0 сая төгрөг
- “Шаргал тариа” ХХК Гурилын үйлдвэр барих зориулалтаар 500,0 сая төгрөг, бүгд 2500,0 сая төгрөг

2.3 Эдгээр зээл дээрх нэр бүхий 3 компанид олгогдсон мэт харагдаж байгаа боловч зээл авсан барьцаа хөрөнгө болон батлан даалтыг захирал Л.Чинбат гаргасан бөгөөд эдгээр компаниуд Сэлэнгэ аймгийн Цагаан нуур сумын нутаг дэвсгэрт нэг хашаанд байрлаж байна.



2.4 Гачуурт, Баяндулаан Уул ХХК-иуд 2000 тн хүнсний ногооны агуулах болон мал нядлах, мах ангилан боловсруулах үйлдвэр барьж дууссан ч үйл ажиллагаа нь зогсонги байдалтай (хөргүүр, болон зооринд хадгалсан мах, ногоо байхгүй) байлаа.

2.5 “Гачуурт” ХХК-ийн 1311002001 дугаар, 2054701 РД-тай Улсын бүртгэлийн гэрчилгээнд хүнсний ногооны зоорь ажиллуулах, “Баяндулаан-Уул” ХХК-ийн 1311003055, РД 3734315 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээнд Мал нядлах, мах боловсруулах ажиллагааг эрхлэн явуулах тухай заалт алга байна.



2.6 “Шаргал тариа” ХХК Гурилын үйлдвэр барих зориулалтаар ХХБ-тай 2010 оны 5 дугаар сарын 18-ны өдөр гэрээ байгуулж 3 жилийн хугацаатай 500,0 сая төгрөгийн зээл авсан боловч үйлдвэр барих хугацааны гуравны нэг нь өнгөрч байхад дөнгөж суурийн газар шорооны ажил хийгдсэн төдий байна. (зурагт харуулав)



2.7 ХХБ-наас “Монгол алтан тос” ХХК Эргэлтийн хөрөнгө буюу түүхий эд худалдан авах зориулалтаар 2010 оны 5 дугаар сарын 3-ны өдөр 5 жилийн хугацаатай 850,0 сая төгрөгийн зээл авсан боловч Дархан-Уул аймаг дахь тус компанийн агуулахад худалдаж авсан түүхий эд болох рапс байхгүй байв. Харин тус компанийн захирал Ганзориг Заамарт рапс хадгалагдаж байгаа гэсэн тайлбар гаргаж, зургаар үзүүлж байв.

2.8 Мөн “Монгол алтан тос” ХХК Зоос банктай 2009 оны 10 дугаар сарын 8-ны өдөр 175 дугаар гэрээ байгуулж ЖДҮХС-гийн эх үүсвэрээс 120,0 сая төгрөг авсан боловч уг зээлийг төлөхөөс татгалзжээ. Улмаар Дархан-Уул аймгийн сум дундын шүүхээр уг асуудлыг хянан хэлэлцээд 2010 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 1879 дугаар шийдвэрээр бүгд 124,3 сая төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэсэн боловч өнөөг хүртэл төлөгдөөгүй байна.



“Монгол алтан тос” ХХК-ийн үйлдвэрийн байр

2.9 Нөгөө талаар ХХААХҮС-ын 2010 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 35 дугаар тушаалаар баталсан журмын 3.2.3-т “Татварын болон зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх” гэсэн заалтыг зөрчиж тус компани Чингис хаан банкнаас 7,143,5 сая төгрөгийн төлөгдөөгүй зээлтэй байхад дээрх зээлийг олгожээ. Одоогоор тус үйлдвэрийн дамжлагын техник тоног төхөөрөмжүүд бүрэн суурилагдаагүй, ашиглалтад орох хугацаа тодорхойгүй байна.

2.ХААН банк

2.10 2010 оны 8 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан 565/01 дугаар гэрээний дагуу Өвөрхангай аймагт ЖДҮ-ийг дэмжих зориулалтаар олгосон хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл болох 530,0 сая төгрөгийг аудитын явцад ЖДҮХС-ийн дансанд буцааж төвлөрүүлэв.

2.11 Зээлийн гэрээн дэх утасны дугаарын нилээдгүй хэсэг нь холбогдох боломжгүй, орох ярианы эрх хаагдсан, утас нь өөр хүнд шилжсэн гэсэн хариу өгч байгаа тул зарим аж ахуйн нэгж, байгууллагын авсан зээлийн ашиглалтад аудит хийж чадаагүй болно. Тухайлбал,

• Өнгөлөг трейд ХХК	80,0 сая төгрөг	
• Натурал альфа ХХК	100,0 сая төгрөг	
• Дэлхийн чингис ХХК	60,0 сая төгрөг	
• Баян хангай ХХК	60,0 сая төгрөг	
• Барил трейд ХХК	400,0 сая төгрөг	
• Онцлог хийц ХХК	100,0 сая төгрөг	гэх мэт

3.Хас банк

2.12 Хэнтий болон Төв аймаг дахь тус банкны салбараас хөнгөлөлттэй зээл авсан зарим аж ахуйн нэгж, иргэдийн зээлийн ашиглалтын байдалд аудит хийхэд дараахь зөрчил илэрлээ. Тухайлбал,

- “Умардын Од” ХХК компани сүүний үхрийн ферм байгуулах зориулалтаар ЖДҮХС-гийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан 2009 оны 9 сард 50.0 сая төгрөгийн зээлийг Хас банкаар дамжуулан авч 2010 оны 6 сард Төв аймгийн Батсүмбэр сумаас 6 үнээг нэг бүрийг нь 1.5 сая төгрөгөөр худалдан авч саалийн зориулалтаар ашиглаж байна. Хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл 41,0 сая төгрөгийг өөрийн үндсэн үйл ажиллагаа болох худалдааны бизнест зориулалт бусаар ашиглаж байжээ.
- “Хаан ембүү” ХХК 2009 оны 8 сарын 31-ний өдрийн “Эд хөрөнгө барьцаалан үүрэг хүлээх гэрээ”-г байгуулсан ба барьцаалагчийг төлөөлж Төв аймгийн ХХААЖДҮГ-ын дарга Р.Мөнгөнхайч гарын үсэг зурж, Засаг дарга баталгаажуулснаар 2009 оны 9 сарын 14-нд барьцаат зээлийн гэрээг Хас банктай байгуулан 50,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг авчээ. Гэвч Хас банк тус компанийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтэрсэн гэдэг шалтгаанаар дээрх эд хөрөнгө барьцаалан үүрэг хүлээх гэрээг үндэслэн Хаан ембүү ХХК-ийн зээлийн төлбөр 50,1 сая төгрөгийг ЖДҮХ сангийн хөрөнгөөс 2011 оны 3 дугаар сарын 25-ны өдөр суутган авчээ.
- Төв аймгийн Батсүмбэр сумын 1 дүгээр багийн иргэн Т.Баттөмөр аймгийн ЖДҮХ сангаас 2009 онд модон эдлэл мужааны чиглэлээр 8.0 сая төгрөгийн зээл авсан боловч уг зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, одоогоор Улаанбаатар хотод түр оршин сууж байна.
- “Хаш тун” ХХК Хэнтий аймгийн Хэрлэн суманд хүүхдийн тэжээлийн цех байгуулах чиглэлээр 20.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан боловч энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлээгүй байна. Энэ компани нь иргэдэд эмчилгээний үйл ажиллагаа үзүүлдэг хувийн эмнэлэг байна

4.Хадгаламж банк

2.13 ЖДҮХС-гийн хөрөнгөөс 2009 онд Завхан, Өвөрхангай, Дундговь, Сүхбаатар, Говь-Алтай аймгийн 13 аж ахуйн нэгж, иргэдэд бодлогын зээл олгогдсоноос Дундговь аймгийн “Баянгийн говь” ХХК гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас бодлогын зээлийн үлдэгдэл 27,2 сая төгрөгийг ЖДҮХС-гийн харилцах данснаас суутган тооцсон байна.

5.Голомт банк

2.14 Том зээлдэгчдээс 6 аж ахуйн нэгж аудитад хамрагдсанаас дараахь зөрчлүүд ажиглагдлаа. Үүнд:

- ТСШДК хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагааны журмын 3.3.3-д “татварын болон зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх” гэсэн заалтыг зөрчиж бизнесийн хугацаа хэтэрсэн зээлийн өртэй СХД-ийн “Дорны зам” ХХК-д зээл олгосон байна. Тус компани тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар авсан зээлээс Голомт банкнаас авсан бизнесийн зээлийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн төлбөрт 76,8 сая төгрөг төлсний зэрэгцээ шохой, цемент, хөнгөн цагааны пудр, төмөр замын засварын ажилд нийт 68,8 сая, бүгд 145,6 сая төгрөгийг гэрээнд заасан зориулалтаас өөр зүйлд зарцуулжээ.
- “Зүүнтуруун гурил”ХХК 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдөр Увс аймгийн Баруунтуруунд гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах чиглэлээр 1,0 сая төгрөгийн дүрмийн сантай байгуулагдаж тус банкаас 500,0 сая төгрөг авсан боловч тухайн бүс нутагт ижил төрлийн 2 үйлдвэр ашиглалтад орсон учир Өвөрхангай аймгийн Хархоринд үйлдвэрийн байршлыг шилжүүлнэ гэж өнөөг хүртэл үйлдвэр байгуулагдаагүй байна. Зээлийн гэрээнд “ЖДҮХС-ийн зээл-том” гэж заасан нь юунд ч зарцуулж болохоор, зориулалт нь тодорхойгүй байна.

6.Төрийн банк

2.15 Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тушаалаар баталсан “Активийг ангилах, активийн эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-ийн дагуу олгосон зээлийг ангилж үзэхэд дараахь байдалтай байна. Үүнд:

- Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 361-ээс дээш хоног хэтэрсэн муу ангилалд Сэлэнгэ аймгийн “Түнхий” ХХХ, Ховд аймгийн иргэн Н.Батхүү, Баян-Өлгий аймгийн иргэн А.Жалел;
- Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 181-360-ээс дээш хоног хэтэрсэн эргэлзээтэй ангилалд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэн Г.Төмөрбаатар, Ховд аймгийн иргэн Т.Дамдин нарын зээл хамрагдаж байна.

7.Улаанбаатар банк

2.16 Улаанбаатар банкнаас зээл авсан ихэнх аж ахуйн нэгж, иргэд зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласан боловч зарим зээлдэгчийн зээлийн ашиглалт хангалтгүй байна. Үүнд:

- “Деннисон поинт” ХХК 2010 оны 7 дугаар сард 100,0 сая төгрөгийн зээлийг БНХАУ-аас цагаан хоолны хагас болон бүрэн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар авч “АБЗО” ХХК-тай тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг байгуулсан боловч гэрээ цуцлагдаж, тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй байна.
- “Ай энд Юү тур” ХХК 2010 оны 1 дүгээр сард 77,0 сая төгрөгийн зээл авч зориулалтын дагуу хүүхдийн живхний чанар шалгах лабораторийн тоног төхөөрөмж худалдан авсан боловч үйл ажиллагаа явуулж буй ажлын байр хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг хангаагүйн улмаас Мэргэжлийн хяналтын газар үйл ажиллагааг нь зогсоосон байна
- Мөнх Ундармал ХХК 2009 оны 8 дугаар сард 200,0 сая төгрөгийн зээл авч үйлчилгээний байр худалдан авсан ч гэрчилгээ гараагүй, уг байранд үйл ажиллагаа эхлээгүй, зээлийн эргэн төлөлт 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 14,0 сая төгрөгөөр дутуу байна.

8.Капитрон банк

2.17 Аудитад хамрагдсан нийт 20 аж ахуйн нэгжээс 17 нь авсан зээлээ санхүүгийн тайландаа тусгаж, 3 нь тусгаагүй байна. Тухайлбал,

“Хан-Хөхий хүйс гол” ХХК зээлээ санхүүгийн тайландаа тусгаагүй, “Ариг эрдэнэ” ХХК, “Вижинтрий” ХХК санхүүгийн тайлангаа үзүүлэхээс татгалзсан болно.

2.18 Зээл авсан аж ахуйн нэгж зээлийн хөрөнгөөр тодорхой хэмжээгээр үйлдвэрлэлийн ажлын байр, тоног төхөөрөмжтэй болсон хэдий ч зарим аж ахуйн нэгжийн өөрийн эргэлтийн хөрөнгийн боломж муу, борлуулалт хангалтгүй зэргээс үйл ажиллагаа эрхлэх боломжгүй зогсонги байдалд оржээ. Тухайлбал,

“Хан хөхий хүйс гол” ХХК гахайн фермээ өргөжүүлэх, гахай, тоног төхөөрөмж худалдаж авах, гүний худаг гаргах зориулалтаар 68,3 сая төгрөгийн зээл авсан боловч хийсэн ажлын бодит үр дүн тодорхойгүй;

“ГЭПБ” ХХК 2010 онд бетон эдлэл үйлдвэрлэхээр 60,0 сая төгрөгийн зээл авсан боловч зарим тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулаагүй, үйлдвэрлэл зогсонги байдалд байна;

“ММБ” ХХК 100,0 сая төгрөгийн зээлийг модон эдлэл, тавилга үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар авснаас зарим төхөөрөмж бүрэн суурилагдаагүйгээс ашиглалтад ороогүй, борлуулалт хийгдээгүй;

“Луут хангай” ХХК-ийн 93,0 сая төгрөгийн зиг заг модон шахмал хавтан хийхэд шаардагдах үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмж бүрэн суурилагдаагүйгээс ашиглалтад ороогүй, борлуулалт хийгдээгүй байна;

2.19 Мөн 2010 онд зээл авсан зарим аж ахуйн нэгжүүдэд ажлын байр нэмэгдсэн гэх боловч газар дээр нь очиж үзэхэд ихэнх тохиолдолд түр болон гэрээт ажилтнууд авч ажиллуулсан байна.

9.Үндэсний хөрөнгө оруулалтын банк

2.20 Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 475/182 тушаалаар баталсан “Активийг ангилах, активийн эрсдлийн сан байгуулж зарцуулах журам”-ийн дагуу “Дээд өнгө” ХХК, 800,0 сая төгрөгийн зээлийн өр хугацаа хэтэрч, “Висдом Ассетс холдинг”ХХК-ийн 600,0 сая төгрөгийн төслийн хөнгөлөлттэй зээл хэвийн бус зээлийн ангилалд хамаарагдах болжээ.

2.21 ЖДҮГ-ын тайлангаар нийт 45 ажлын байр шинээр нэмэгдсэнээр тайлагнасан боловч тухайн ААН-ийн ХХОАТ болон НДШ-ийн тайлангаар 10 ажлын байр нэмэгдсэн байна.

Санхүүгийн түрээсийн зээлийн тухай

2.22 Засгийн газраас баталсан “Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл”, “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор санхүүгийн түрээсийн лизингийн үйлчилгээ үзүүлэхээр ХХААХҮС-ын 2010 оны А/184 дугаар тушаалаар “Санхүүгийн түрээс лизингийн журам” батлагдсан.

“Эн Ви Си ХХК” ББСБ

2.23 ЖДҮХС “Эн Ви Си” ББСБ-тай 2010 оны 6 дугаар сарын 9-ний өдөр 06/02 дугаар хамтран ажиллах гэрээ байгуулж, ЖДҮ, үйлчилгээг дэмжих зорилгоор санхүүгийн түрээсийн үйлчилгээг үзүүлэх зориулалтаар 600,0 сая төгрөгийг сарын 0,1 хувийн хүүтэйгээр, 48 сарын хугацаатай олгожээ.

2.24 Гэрээний 2.6-д “Санхүүгийн түрээсийг олгохдоо Засгийн газраас ЖДҮ-ийг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, ХХААХҮЯ-наас баримталж буй сүү, арьс шир, хонины ноос боловсруулах, тэжээл бэлтгэхэд шаардлагатай жижиг, дунд оврын тоног төхөөрөмж үйлдвэрлэгч үйлдвэрүүдийг тэргүүн ээлжинд дэмжихэд анхаарч ажиллах” тухай заажээ.

2.25 “Эн Ви Си” ББСБ энэхүү санхүүжилтээс 2011 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 14 аж ахуйн нэгж, байгууллагад бүгд 482,6 сая төгрөгийг олгож, 117,4 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

2.26 Аудитад 4 аж ахуйн нэгж хамрагдсанаас дараахь зөрчил илэрлээ. Үүнд:

- “Эн Ви Си” ББСБ 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдөр өөрийн хөрөнгө оруулсан, 60 хувийн хувьцааг нь эзэмшдэг (өмнө нь 100% эзэмшиж байсан) “Пенохийц” ХХК-д 100,0 сая төгрөгийн зээл олгосон;
- Мөн тус ББСБ “И Эф И” ХХК-д 100,0 сая төгрөгийг сарын 0,9 хувийн хүүтэй, 15 сарын хугацаатай зээл олгохоор 2011 оны 2 дугаар сарын 28-ны өдөр гэрээ хийгдэж, урьдчилгаа 39,0 сая төгрөг олгогджээ. Гэтэл “И Эф И” ХХК-ийн 2011 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын 11/004 дугаар тогтоолоор “Эн Ви Си” ББСБ нь тус компанийн хувьцааны 35 хувийг эзэмшигч болжээ. Өөрөөр хэлбэл ЖДҮХС-гийн хөрөнгийг ЖДҮ, үйлчилгээг дэмжих

зориулалтаар бус хувьцаа эзэмшигч компанийхаа үйл ажиллагаандаа ашигласан байна.

- “Эн Ви Си” ББСБ-ын дэд захирал Б.Түмэндэлгэр 2010 оны 12 сарын 29-ний өдөр “Хаан ембүү” ХХК-тай (гүйцэтгэх захирал О.Бадрал гэж гарын үсэг зурсан) санхүүгийн түрээсийн гэрээ хийж 60,0 сая төгрөгийг сарын 0,9 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай олгожээ. Гэтэл тухайн үед болон одоогоор “Эн Ви Си” ББСБ-ын гүйцэтгэх захирлаар О.Бадрал ажиллаж байгаа атал “Хаан ембүү” ХХК-ийн захирлын ажлыг давхар гүйцэтгэдэг (“Эн Ви Си” ББСБ нь “Хаан ембүү” ХХК-ийн 30 хувийн хувьцааг эзэмшдэг) компанидаа санхүүгийн зээл олгожээ.

2.27 “Эн Ви Си” ББСБ санхүүгийн дэмжлэг хүссэн ААНБ-ын дүрмийн санд хөрөнгө оруулалт хийн хувьцаа эзэмшиж, улмаар удирдлагын бүтцэд орон, менежментийн бодлогыг явуулж, үйл ажиллагаа нь сайжирсан нөхцөлд, оруулсан хөрөнгөө буцааж аваад гардаг шинэ үйлчилгээний хэлбэр гэж тайлбарлаж байна.

Сүү үндэсний хөтөлбөр

2.28 “Сүү” болон “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээг нэмэгдүүлэх, сүү боловсруулах үйлдвэр байгуулах төслийн шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгж, иргэдэд ХХААХҮС-ын тушаалаар хүүгүй зээл олгожээ. Үүнд:

- ХХААХҮС-ын 2009 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 180 дугаар тушаалаар нэр бүхий 21 аж ахуйн нэгж, иргэнд нийт 450,0 сая төгрөг
- ХХААХҮС-ын 2010 оны 4 дүгээр сарын 19-ний А/86 дугаар тушаалаар нэр бүхий 16 аж ахуйн нэгж, иргэнд нийт 485,0 сая төгрөг

2.29 Дээрх зээл авсан 37 аж ахуйн нэгж, иргэдэд нийт 935,0 сая төгрөг олгогдсоноос 16-д нь буюу 43,2 хувьд аудит хийхэд дараахь байдалтай байв.

2.30 Үйлдвэр байгуулж, сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж сүүний хэмжээг нэмэгдүүлэх зориулалтаар олгосон зээлийг зориулалт бусаар ашиглаж байгаа аж ахуйн нэгж, иргэд цөөнгүй байна. Тухайлбал,

- “Агрико-Эрдэнэ” ХХК (Төв аймгийн Эрдэнэ сум) 2009 онд 20,0 сая төгрөгийн зээл авсан боловч сүү боловсруулах үйлдвэрлэл эрхлээгүй, харин нэрсний чанамал, улаан лоолийн сүмс үйлдвэрлэж байна.
- “Тод Шим” ХХК (Төв аймгийн Бор нуур сум) 2009 онд сүү хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор 15,0 сая төгрөг авсан боловч энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй, харин тус компани нь хадгаламж, зээлийн үйлчилгээ болон ломбардын үйлчилгээ эрхэлдэг байна.
- “Хоролтрейд” ХХК (Төв аймгийн Батсүмбэр сум) 2009 онд сүү боловсруулах бичил сүлжээ төсөл хэрэгжүүлэхээр 20,0 сая төгрөг авсан боловч 2010 онд бүх үхрээ худалдан борлуулж, үйл ажиллагаа явуулаагүй.
- Скай бросс ХХК (Төв аймгийн Дэлгэрхаан сум) сүүний цех байгуулахаар 2010 онд 30,0 сая төгрөг авсан боловч үйл ажиллагаа явуулаагүй.
- “Монлайф” ХХК(УБ хот) 2010 онд сүү боловсруулах үйлдвэрийн төслөөр 30,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан боловч тоног төхөөрөмжийг бүрэн худалдан аваагүй, байрны бололцоогүй гэдэг шалтгаанаар үйлдвэрлэл явуулаагүй.

- “Хан өндөр хайрхан” ХХК (УБ хот) 2010 онд сайн чанарын сүүний үйлдвэр байгуулах төслөөр 30,0 сая төгрөгийн зээл авсан ч сүүний чиглэлээр үйлдвэрлэл явуулаагүй, харин эмийн худалдааны үйл ажиллагаа эрхэлж байна.
- “Лха Түшиг” ХХК (УБ хот) 2010 онд Сүү боловсруулах үйлдвэрлэлийн төслөөр шалгарч 30.0 сая төгрөгийн зээл авсан боловч техник тоног төхөөрөмжөө бүрэн аваагүй гэдэг шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй.
- Иргэн Ц.Энхсайхан (Төв аймаг, Баянчандмань сум) 2010 онд сүү, сүүн бүтээгдэхүүний жижиг үйлдвэр байгуулах зорилгоор 25,0 сая төгрөг авсан ч тухайн суманд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж үйлдвэр байгуулаагүй.
- “Мах Экспорт” ХХК (УБ хот) 2010 онд мах боловсруулах үйлдвэр дотоод хяналтын лаборатори байгуулахаар “Сүү” хөтөлбөрөөс 35,0 сая төгрөгийн хүүгүй зээлд хамрагдсан байна.

2.31 Сүүний үйлдвэр болон цех байгуулсан боловч үйл ажиллагаагаа эхлүүлээгүй аж ахуйн нэгж, иргэдийг дурдвал;

- “Инцептум” ХХК 2009 онд Сүү боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 60.0 сая төгрөгийн зээл авсан боловч үйлдвэр нь туршилтын хугацаанд амжилтгүй болж цаашид үйлдвэрлэл хэвийн явуулах боломжгүй болсон;
- “Цагаан сувд” ХХК 2009 онд сүү цуглуулах хөргөх төв байгуулах зорилгоор 20,0 сая төгрөгийн зээл авч техник хэрэгсэл, лабораторийн зарим багаж төхөөрөмж авсан боловч цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, үйл ажиллагаа эхлээгүй байна.

2.32 ХХААХҮЯ-ны ЖДҮХС-гаас үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээг нэмэгдүүлэх, сүү боловсруулах үйлдвэр байгуулах зорилгоор олгосон 16 аж ахуйн нэгж, иргэд аудитад хамрагдсанаас 11 нь зөрчилтэй байлаа.

Төслийг хэрэгжүүлснээр тухайн нэгжид ажлын байр болон төсвийн орлого нэмэгдэж байгаа нь баримтаар бүрэн нотлогдохгүй байна

2.33 ЖДҮХС-гаас 2009-2010 онд олгогдсон хөнгөлөлттэй зээлийн үр дүнд бий болсон ажлын байрны судалгаагаар 2009 онд 5255, 2010 онд 3874, бүгд 9129 ажлын байр шинээр нэмэгдэж, 4327 ажлын байр хэвээр хадгалагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

2009-2010 онд олгогдсон хөнгөлөлттэй зээлийн үр дүнд бий болсон ажлын байрны судалгаа

Д/д	Банк	Аймгийн нэр	2009 онд	2010 онд						2009, 2010 онд	
			Шинээр	Эргэн төлөлтөөс		2010 оны зээл		НИЙТ		Шинээр	Хадгалагдах
				Шинээр	Хадгалагдах	Шинээр	Хадгалагдах	Шинээр	Хадгалагдах		
1	Хаан банк	Говьсүмбэр	78			142	62	142	62	220	62
2		Дорнод	113	19	17	203	114	222	131	335	131
3		Сүхбаатар	236			85	31	85	31	321	31
4		Булган	562			106	87	106	87	668	87
5		Хэнтий	155			106	125	106	125	261	125

6		Ховд	225	37	122	122	194	159	316	384	316
Дүн			1,369	56	139	764	613	820	752	2,189	752
7	Хадгаламж банк	Говь-Алтай	241			177	108	177	108	418	108
8		Өвөрхангай	330			95	149	95	149	425	149
9		Дорноговь	82			199	137	199	137	281	137
10		Дундговь	113			76	49	76	49	189	49
11		Орхон	107			89	113	89	113	196	113
12		Завхан	114			121	127	121	127	235	127
13		Архангай	173	70	30	137	138	207	168	380	168
14		Хөвсгөл	391	82	115	229	84	311	199	702	199
15		Сэлэнгэ	158	18	14	268	232	286	246	444	246
Дүн			1,709	170	159	1,391	1,137	1,561	1,296	3,270	1,296
16	Хас банк	Баянхонгор	182			196	333	196	333	378	333
17		Дархан-Уул	134			155	229	155	229	289	229
18		Увс	117			151	153	151	153	268	153
19		Төв	192			245	139	245	139	437	139
20		Өмнөговь	99			60	60	60	60	159	60
21		Баян-Өлгий	361	54	51	108	188	162	239	523	239
Дүн			1,085	54	51	915	1,102	969	1,153	2,054	1,153
Орон нутагт			4,163	280	349	3,070	2852	3,350	3,201	7,513	3,201
1	УБ	Голомт		2	8	53	220	55	228	55	228
2		Капитрон	358			227	415	227	415	585	415
3		Улаанбаатар	592	19	64	223	419	242	483	834	483
4		Төрийн банк	30							30	0
5		Хадгаламж	68							68	0
6		ХАС	44							44	0
	Хот	6 банк	1092	21	72	503	1054	524	1,126	1,616	1,126
Дүн			5255	301	421	3,573	3906	3,874	4,327	9,129	4,327

2.34 Дээрх хүснэгтээс харахад ЖДҮХС-аас олгосон хөнгөлөлттэй зээлийн үр дүнд 2009 оны 12 сарын 31-ний байдлаар 5255 ажлын байр шинээр нэмэгдэж, нэг ажлын байрны өртөг 6.608 мянган төгрөг, 2010 оны 12 сарын 31-ний байдлаар 3874 ажлын байр шинээр нэмэгдэж, нэг ажлын байрны өртөг 6.931 мян.төгрөг болж нэмэгдсэн байна.

2.35 ЖДҮХС-гаас 2009-2010 онд 3332 ААНБ, иргэд хөнгөлөлттэй зээлд хамрагдсанаас аудитын явцад зарим аж ахуйн нэгж, байгууллагад очиж тайлан тэнцэл, байгууллагын гэрчилгээ, ХХОАТ, НДШ-ийн тайлан болон арилжааны банк, ЖДҮХС-аас гаргасан судалгаа зэрэгтэй танилцахад ажлын байрны тооны талаар дараахь зөрчил илэрч байна.

(тоогоор)

№	Арилжааны банкууд	Банкны тайланд	ААН-ийн албан тоот болон ХХОАТ, НДШ-ийн тайлангаар
	<i>Хаан банк</i>		
1	“Prestige food” ХХК	15	15
2	“Монгол гэр хужирт” ХХК	11	15
3	“Өгөөмж Архад”	130	8
4	“Сор кашмир” ХХК	7	8
5	“Авто 103” ХХК	7	6
ДҮН		170	52
№	<i>Худалдаа хөгжлийн банк</i>	-	-
1	“Магнет Импорт” ХХК	7	9
2	“Малчин” ХХК	3	7
ДҮН		10	16
№	<i>Хадгаламж банк</i>	-	-
1	Түмэн шувуут	30	8
2	Мон Мэс	5	10
ДҮН		35	18
№	<i>Капитрон банк</i>	--	-
1	“Хан хөхийн хүйс гол” ХХК	6	2
2	Ди Ди Би	10	3
3	Ариг Эрдэнэ	10	4
4	Монгол Киёши	12	8
5	Сэрүүн	17	10
ДҮН		55	27
БҮГД		270	113

2.36 Дээрх хүснэгтээс үзэхэд банкны байгууллагаас гаргасан судалгаагаар 14 аж ахуйн нэгжид 270 ажлын байр шинээр нэмэгдсэн гэж тайлагнасан байхад аж ахуйн нэгж, байгууллагын тайлан, холбогдох бусад баримт материалаас үзэхэд 113 ажлын байр шинээр нэмэгдсэн байна.

2.37 Үүнээс үзэхэд зээл авсан аж ахуйн нэгж нь ажлын байр нэмэгдүүлэн ажилтан авч ажиллуулж байгаа боловч авсан зээлээ тайлан тэнцэлдээ тусгаагүй, ажилтны цалин хөлсийг өгч байгааг нотлох баримтгүй, ХХОАТ, НДШ-ийг суутган төсөвт төлөөгүй зэргээс ажлын байр шинээр нэмэгдээгүй мэт харагдаж байна.

2.38 ЖДҮ эрхлэгчдийг санхүүгийн анхан шатны бүртгэл хэрхэн хөтлөх, ажилтан авч ажиллуулж байгаа нөхцөлд ямар үүрэг хариуцлага ногдох талаархи сургалтыг бүх шатанд явуулах нь зүйтэй байна.

ДУГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

- ЖДҮ-ийг дэмжих үүрэг бүхий ЖДҮГ, ЖДҮХС, ЖДҮДТ болон бусад ижил төстэй хөтөлбөрүүд нэгдсэн бодлого, чиглэлгүй тус тусдаа бие даан үйл ажиллагаа явуулж байгаа нь чиг үүргийн давхардал бий болгох, хөрөнгө мөнгө үргүй зарцуулах нөхцлийг бий болгож байна. Өмнөх аудитаар өгсөн ЖДҮ-ийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын бүтэц, орон тоог оновчтой болгох зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулж буй зарим эрх зүйн актууд хоорондоо уялдаа муутай, ЖДҮТХ-д хуулийн нэр, бизнес эрхлэгч байгууллагуудын тодорхойлолт зэрэг нь оновчгүй байна.
- ТСШК, ТСШДК нь ЖДҮ-ийг хөгжүүлэх зорилгоор арилжааны банкаар дамжуулан зээл олгох комиссын үйл ажиллагааны журмыг бүрэн баримталж ажиллаагүй, төслийн шинжилгээ судалгааг сайн нягтлахгүйгээр банкны шалгуурт хэт найдаж байгаа нь зээлийн зориулалт, үр дүнг эрсдэлд оруулах нөхцлийг бүрдүүлж байна.
- Санхүүгийн түрээсийн зээл авсан ББСБ уг хөрөнгийг хувьцааг нь эзэмшдэг компаниудад зээлдүүлэх, үлдэгдлийг өөрийн үйл ажиллагаанд ашиглаж байна.
- 2009, 2010 онд хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгж, байгууллага зээлийн хөрөнгийг төсөл болон гэрээнд заасны дагуу зарцуулахгүй тохиолдол гарч байна.
- “Сүү” болон “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээг нэмэгдүүлэх, сүү боловсруулах үйлдвэр байгуулах зориулалтаар төслөөр олгосон хүүгүй нөхцөлтэй зээлийн нилээдийг нь зориулалт бусаар ашиглаж байна.
- 2010 онд ЖДҮХС-гаас олгосон хөнгөлөлттэй зээлд аймаг, орон нутгийн удирдлага батлан даалт гаргах, эд хөрөнгийг барьцаалах үүрэг хүлээснээс зарим аж ахуйн нэгжийн хугацаандаа төлөгдөөгүй зээлийн өр төлбөрийг арилжааны зарим банкууд тус сангийн данснаас суутган тооцож авсан байна.
- ЖДҮХС-гаас арилжааны банкуудаар дамжуулан аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээл ашиглалтын үр дүнд татвар ногдох орлого, ажлын байр нэмэгдэж байгаа боловч зарим ААН-д ажлын байр шинээр нэмэгдсэн талаархи баримт материал алга байна. Нөгөө талаар шинэ ажлын байрны тоо, ажлын байрны нэгж өртгийн талаар хийсэн дүн шинжилгээ, судалгаа материал, тооцох аргачлал ХХААХҮЯ, ЖДҮГ, ЖДҮХС-д алга байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд

- ЖДҮГ, ЖДҮХС, ЖДҮДТ болон яамны газар хэлтсийн чиг үүргийг уялдуулах асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулж буй хууль эрх зүйн орчин, зөрчилтэй хуулиудын заалтыг цэгцлэх асуудлыг судалж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
- “Сүү” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд ЖДҮХС-гаас хүүгүй олгосон зээлийн ашиглалт, хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж, энэ хөтөлбөрийн хүрээнд олгосон бүх зээлийн үйл ажиллагаа, үр дүнд иж бүрэн шалгалт хийж дүнг ирүүлэх;
- ЖДҮХС-гийн эх үүсвэрээр зээл авсан зээлдэгчийн мэдээллийг төрийн аудитын байгууллагад гаргаж өгч байх талаархи заалтыг гэрээнд тусгах, энэ заалтыг хэрэгжүүлээгүй арилжааны банкуудад дахиж зээл олгохгүй байх арга хэмжээ авах;
- Санхүүгийн түрээсийн зээлийн зориулалт, ашиглалтын хэлбэрийг нарийн тогтоож, үр дүнг хэрхэн тооцож байх асуудлыг тодорхой болгож журамд нийцүүлэх.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирал М.Баярмагнайд

- Арилжааны банкуудад аж ахуйн нэгж, байгууллагуудаас төлсөн зээлийн эргэн төлөлтийг ЖДҮХС-гийн дансанд бүрэн төвлөрүүлж байх;
- Хөнгөлөлттэй зээл авсан зарим аж ахуйн нэгж, байгууллага зээлийн хөрөнгийг төсөл болон гэрээнд заасны дагуу зарцуулаагүй байгаад дүгнэлт хийж, дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог бий болгох;
- Зээлийн гэрээний үүргийн биелэлтийг нарийн дүгнэж, гэрээнд заасан хариуцлагыг тооцож байх, зээл авч байгаа аж ахуйн нэгж, иргэдийн оршин суугаа хаяг, холбогдох утасны дугаарыг тодорхой бичих, хэрэв дээрх зүйлс өөрчлөгдсөн тохиолдолд ЖДҮХС-д тухай бүр мэдэгдэж байх заалтыг гэрээнд оруулах

Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Ц.Ням-Осорт

- ЖДҮ-ийг хөгжүүлэх, ажлын байр шинээр нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагад олгож буй зээлийн ашиглалтын байдалд тавих хяналтыг сайжруулах, зээлийн үйл ажиллагааны үр дүнд бодитой нэмэгдсэн ажлын байрны тоо, түүнийг бий болгоход гарч буй өртөг зардлын шинжилгээ хийж, түүнд тулгуурлан ЖДҮ-ийг хөгжүүлэх бодлогыг оновчтой тодорхойлоход ашиглах явдлыг хэвшүүлэх.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-31-21,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2011.09.06 № 112841
танай 2011.08.25-ны № 643 -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ


Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2010 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд хийж байгаа тайлбар, тодруулгыг хавсралтаар гарган хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: ...5 хуудас.


ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

ТАНТУЛГА



00804790

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
2011 оны 9 дүгээр сарын 06- ний өдрийн
..... тоотын хавсралт



**Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр
2009-2010 онд улсын төсвөөс олгосон хөрөнгийн
зарцуулалт, зээлийн ашиглалтад
Үндэсний аудитын газраас хийсэн
үнэлгээний тайлбар**

Нэгдүгээр бүлэг:

1.16 хүрээнд:

Тайлбар: Монгол Улсын Их Хурлаас 2006 онд батлагдсан “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 5.4.6 дахь хэсэг, 14 дүгээр зүйлүүдэд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан” гэж байхаар хуульчлан баталгаажуулж өгсөн. 2007 онд батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийн 22 дэх зүйлийн 22.1-д “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан байна”, 22.2-д “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна” гэж тодорхой зааж өгсөн.

Монгол Улсын Их Хурлаас “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийг хэрэгжүүлэх үүднээс “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 51 дүгээр тогтоолыг 2007 онд баталсны дагуу “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолд нэмэлт оруулж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрыг Үйлдвэр, худалдааны сайдын /хуучнаар/ эрхлэх асуудлын хүрээнд байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Агентлагийг зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл, агентлаг байгуулахтай холбоотой холбогдох хууль эрх зүйн өөрчлөлтийг боловсруулахад чиглүүлсэн Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолыг гаргасан.

Дээрх тогтоол нь “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль” болон өмнөх 51 дүгээр тогтоолын хэрэгжилтийг түргэтгэх зорилготой бөгөөд 52 дугаар тогтоолын 3 дугаар хэсэгт “Жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сангууд болон төслүүдийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн бүтцэд шилжүүлэхтэй холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж Засгийн газарт даалгасан боловч энэ асуудлаар Засгийн газар шийдвэр гаргаагүй. Өнөөдөр Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 26.3-т “сангийн хөрөнгийг захиран зарцуулах

шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн сан нь “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 – т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийн газарт бус салбар хариуцсан Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байгаа юм.

Улсын Их Хурлын 43 дугаар тогтоолыг 2008 онд шинэчлэн баталсан бөгөөд энэ тогтоолоор Улсын Их Хурлын 14 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон. Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Улсын Их Хурлын 2007 оны 51,52 дугаар тогтоолын үйлчлэх хүрээ хязгаарлагдсан.

ХХААХҮ-н яам нь ҮАГ-аас 2010 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн дагуу сангийн бүтцийн дагуу бүх яамдаас санал авч нэгтгэн Засгийн газарт оруулсан бөгөөд холбогдох шийдвэр эцэслэн гараагүй байна.

Тайлбар 1

Санал: Улсын Их Хурлын 43 дугаар тогтоолыг 2008 онд шинэчлэн баталсан бөгөөд энэ тогтоолоор Улсын Их Хурлын 14 дүгээр тогтоолыг хүчингүй болгосноор Улсын Их Хурлын 2007 оны 51,52 дугаар тогтоолын үйлчлэх хүрээ хязгаарлагдсан.

Тайлбар 2

1.18 хүрээнд:

Тайлбар: ЖДҮХСангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн талаарх найруулгын хувьд “57,9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.” гэж бичсэн нь сангаас банкинд байршуулаад эргүүлэн аваагүй юм шиг санааг төрүүлж байна.

Санал: Энэ өгүүлбэрийн “57,9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.” гэснийг “57,9 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.” найруулах саналтай байна.

Тайлбар 3

1.33-34 хүрээнд:

Тайлбар: Дээрх аж ахуйн нэгжүүдээс “Оргил констракшн” ХХК нь зээлээ төлсөн ба бусад аж ахуйн нэгжүүдийн хувьд ЖДҮХСангаас шүүхэд хандаж бүх асуудлыг шүүхийн шийдвэр гаргуулж төлүүлэхээр шийдвэрлэгдсэн болно.

Санал: “нэхэмжлэн авч,” гэсний арын “сангаас хохиролгүй болгох нь зүйтэй гэж үзэв” гэснийг өөрчлөн найруулж “ЖДҮХСангаас зээлийн эргэн төлөлт хийгдээгүй аж ахуйн нэгжүүдийн асуудлыг холбогдох хууль журмын хүрээнд шүүхээр шийдвэрлүүлж, эргэн төлөлтийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна.” гэж найруулах саналтай байна.

Тайлбар 4

2.28 Сүү үндэсний хөтөлбөр:

Сүү үндэсний хөтөлбөр нь ХХААХҮ-н яаман дээр хэрэгжиж байгаа төсөл тул ЖДҮХС-д хийсэн аудитын тайлангаас салгаж яамны аудитын тайланд тусгаж өгөх нь зүйтэй байна.

Тухайн төслийн сонгон шалгаруулалт болон гүйцэтгэлийн хяналт, шалгалт яаман дээр хийгдэж “Сүү” болон “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийн зорилтийн биелэлтийг гаргаж байгаа болно.

Санал: Иймд Сүү үндэсний хөтөлбөрийн холбогдолтой зөрчил, төлбөрийг сангийн аудитын тайлангаас хасуулах саналтай байна.

Аудитын дүгнэлт хэсэгт:

Дүгнэлт 1-ийг хасах.

Тайлбар 5

Тайлбар: Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь арилжааны банкаар болон өөрөө бие дааж зээл олгох эрх зүйн орчин бүрдсэн болно. Энэ ч үүднээс олон тэрбум төгрөгийн санхүүжилтийг жижиг, дунд үйлдвэрийг төрөөс дэмжихээр санхүүжилт олгож байна. Өнөөдөр манай улсын арилжааны зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй дундаж арилжааны банкны дүрмийн сан нь тус сангийн хөрөнгөтэй энэ тэнцүү байгаа бөгөөд тэдгээр нь доод тал нь 150-200 мэргэшсэн боловсон хүчинтэй ажиллаж байна. Ийм учраас Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь мэргэшсэн, цомхон боловсон хүчинтэй байх нь нэн тэргүүний зорилт болоод байна. Энэ нь олон тэрбум төгрөгийн зээл олголтын мэдээ, тайлан, эргэн төлөлтийг төвлөрүүлэх, эрсдлийг тооцох, арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах, олон улсын байгууллага, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрөөс жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээрх хөрөнгө мөнгө төвлөрүүлэн хамтран ажиллаж сангийн хөрөнгийг арвижуулах, зүй зохистой зарцуулах эрх зүйн чадамж бүхий хуулийн этгээд байх нь зүйтэй юм.

Жижиг, дунд үйлдвэрийн газар нь “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасны дагуу:

- жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбар, чиглэлийн талаар санал боловсруулах;
- жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авах санал боловсруулж зохих байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;
- жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах;
- жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим, төрийн бус бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;
- жижиг, дунд үйлдвэрийн талаар шаардлагатай судалгааг тогтмол явуулж, үр дүнг нийтэд мэдээлэх зэрэг төрөөс баримтлаж буй бодлогын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлаг юм.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасны дагуу:

- ажлын байр бий болгох;
- жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд зориулж урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох;

- зээлийн баталгаа гаргах;
- мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
- сургалт, давтан сургалтад хамруулах;
- зарим төрлийн даатгалд хамруулах зэрэг үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх эрх бүхий хуулийн этгээд юм.

Жижиг, дунд үйлдвэрийн газар болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хуулиар олгогдсон эрх үүргийг харьцуулж үзэхэд ижил үйл ажиллагааны давхардал үгүй болох нь тодорхой харагдах ба тус тусын хариуцсан чиг үүрэгтэй гэдгийг зааж өгсөн болно.

Тайлбар 6

Дүгнэлт хэсэг:

Дүгнэлт 4-ыг өөрчлөн найруулах.

Санал: Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй 2010 онд байгуулсан хамтран ажиллах гэрээг шинэчлэн найруулж өмнөх онд гарсан алдаа дутагдлыг арилгах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Энэ хүрээнд санхүүгийн түрээсийн санхүүжилтийг зээлийг олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд ЖДҮХСангаас шилжүүлж байхаар гэрээнд тусгасан болно.

Тайлбар 7

Дүгнэлт 5-г өөрчлөн найруулах.

Тайлбар: Арилжааны банкуудтай 2010 онд байгуулсан гэрээг 2011 онд оны 6 дугаар сард шинэчилэн байгуулсан ба энэхүү гэрээнд “хөнгөлөлттэй зээлийг зориулалт бусаар ашигласан шалгалтын явцад тогтоогдсон аж ахуйн нэгж, иргэний зээлийг арилжааны банкны зээл шилжүүлэх эсвэл зээлийг эргүүлэн төлүүлэх болно” гэж тусгаж өгсөн болно.

Тайлбар 8

Дүгнэлт 7-г өөрчлөн найруулах.

Тайлбар: ЖДҮХСангаас төсөл хэрэгжүүлэгчид батлан даалт гаргах эрх зүйн орчин болсон журмыг өөрчлөн найруулж шинэчлэн ХХААХҮСайдын 2010 оны 35 дугаар тушаалаар баталсан. Зээлийн батлан даалтаас үүдэн ЖДҮХСангаас арилжааны банкуудын суутгасан санхүүжилтийг эргүүлэн төвлөрүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж, шүүхээр зохих шийдвэрүүдийг гаргуулан эргэн төлөлтүүд төвлөрч эхлээд байгаа болно.

Тайлбар 9

Дүгнэлт 9-г хасах.

Улсын Их Хурлын 43 дугаар тогтоолыг 2008 онд шинэчлэн баталсан бөгөөд энэ тогтоолоор Улсын Их Хурлын 14 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон. Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Улсын Их Хурлын 2007 оны 51,52 дугаар тогтоолын үйлчлэх хүрээ хязгаарлагдсан. Энэ асуудлаар дээд шүүхээр тайлбар гаргуулахыг хүссэн ч тайлбар гаргаж өгч чадахгүй гэсэн үндэслэлээр гацсан.

Зөвлөмж:

Тайлбар 10

ЖДҮХСангийн Захирал М.Баярмагнайд

Зөвлөмж 1-ийн хүрээнд:

2009, 2010 онуудад арилжааны банкуудтай байгуулсан гэрээг 2011 оны 5-6 дугаар сард шинэчлэн байгуулсан ба энэхүү шинэчилсэн гэрээний хүрээнд арилжааны банкуудад төвлөрсөн эргэн төлтийн хөрөнгийг улирал бүр банктай тооцоо нийлж ЖДҮХСангийн Төрийн сангийн дансанд төвлөрүүлж байхаар гэрээлсэн болно.

Зөвлөмж 2-ын хүрээнд:

Арилжааны банкуудтай 2010 онд байгуулсан гэрээг 2011 онд оны 6 дугаар сард шинэчилэн байгуулсан ба энэхүү гэрээнд "хөнгөлөлттэй зээлийг зориулалт бусаар ашигласан шалгалтын явцад тогтоогдсон аж ахуйн нэгж, иргэний зээлийг арилжааны банкны зээл шилжүүлэх эсвэл зээлийг эргүүлэн төлүүлэх болно" гэж тусгаж өгсөн болно.

Зөвлөмж 3-ын хүрээнд:

Арилжааны банкуудтай 2011 онд шинэчилж байгуулсан гэрээний хавсралтад энэхүү асуудлыг нарийн тусгаж өгсөн ба аж ахуйн нэгж бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг сар бүрээр авч байхаар гэрээлсэн болно.

Үндэсний аудитын газрын тайлбар

Тайлбар 1

Улсын Их Хурлын 2007 оны 51, 52 дугаар тогтоолоор 2004 оны 14 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулсан. Иймд саналыг хүлээн авах боломжгүй байна.

Тайлбар 2

Саналыг хүлээн авч тайланд засвар хийлээ.

Тайлбар 3

Энэ асуудал нь аудит дуусч тайлагнах үед хийгдэж эхэлсэн учир саналыг хүлээн авах боломжгүй байна.

Тайлбар 4

Сүү хөтөлбөрийн санхүүжилт нь ЖДҮДС-гаар дамжин санхүүжиж байгаа учир саналыг хүлээн авах боломжгүй байна.

Тайлбар 5

Аудитын баг төрөөс явуулж буй ЖДҮ-ийг дэмжих үүрэг бүхий байгууллагуудын нэгдсэн бодлого, чиглэл уялдаа холбоо муутай гэж үзсэн учир дээрх саналыг хүлээн авах боломжгүй байна.

Тайлбар 6

Аудитад 2010 оны үйл ажиллагаа хамарсан бөгөөд санхүүгийн түрээсийн гэрээнд 2011 онд өөрчлөлт хийгдсэн учир дүгнэлтийн агуулгыг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ. Дүгнэлтэд найруулгын өөрчлөлт хийлээ.

Тайлбар 7

Дүгнэлтэд найруулгын өөрчлөлт хийлээ.

Тайлбар 8

Зөрчил гарсан хугацааг нэмж тусгалаа.

Тайлбар 9

1 дүгээр дүгнэлттэй нэгтгэлээ.

Тайлбар 10


Аудитын дүнг үндэслэж хийсэн зөвлөмж учир өөрчлөх шаардлагагүй гэж үзэв.

ЖДҮГ, ЖДҮХС, БИТ-үүдийн дүрмээр тодорхойлсон үйл ажиллагааны зорилт, чиглэлүүд

ЖДҮГ	ЖДҮХС	ЖДҮД Төв (БИТ)
<u>Жижиг, дунд үйлдвэрийн газрын бүрэн эрх</u>	<u>Сангийн зорилго</u>	<u>Нийтлэг үндэслэл</u>
<p>Жижиг, дунд үйлдвэр, хоршоог хөгжүүлэх талаарх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах</p> <p>Жижиг, дунд үйлдвэр, хоршооны талаарх хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах</p> <p>Үйлдвэрлэл хэрэглээний зохистой харьцаа бүхий бүтцийг бий болгох, тэргүүний техник, технологийг импортлох, нутагшуулах, боловсруулах үйлдвэрийн өсөлтийг нэмэгдүүлэх</p>	<p>Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг өргөжүүлж, ажлын байр бий болгоно.</p>	<p>Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, ААН-д бизнесний сургалт явуулах, зөвлөгөө өгөх, мэдээллийн нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлэх зэргээр төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах, төвийн байр талбайн багтаамжаас хамааран тодорхой тооны шинээр бизнес эрхлэгчийг тодорхой хугацаанд төвд бойжуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх замаар зах зээлд гарахад туслах үндсэн чиг үүрэг бүхий Улсын төсөвт үйлдвэрийн газар мөн.</p>
<p>Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, хоршоологчдод сургалт явуулж, зөвлөгөө өгөх, дэмжиж туслах төв, инкубатор байгуулах, тэдгээрийг мэргэжил арга зүй удирдлагаар хангах</p>	<p>Тоног төхөөрөмжийг лизингээр олгох механизмийг бий болгоно.</p>	<p>ЖДҮД Төв нь холбогдох Монгол Улсын ... хуулиуд болон ЖДҮТ хууль, ЗГ-ын жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр, төрөөс баримталж буй бодлого, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна</p>
<p>Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тэргүүлэх чиглэлийн санал боловсруулж, Засгийн газраар хэлэлцүүлж, батлуулах</p> <p>Улсын төсөвт жижиг, дунд үйлдвэр, хоршоог дэмжихэд чиглэсэн төсвийн санал боловсруулах, баталсан төсвийг зохих журмын дагуу зарцуулах</p>	<p>Зах зээлийн харилцаанд зохицсон сургалт зохион байгуулах замаар жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны менежментийн чадавхийг сайжруулж зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн дэмжлэг</p>	<p><u>Үйл ажиллагааны үндсэн чиглэл</u></p>

<p>Жижиг, дунд үйлдвэрийн чиглэлийн талаарх дүрэм, журмуудыг боловсруулан гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>туслалцаа үзүүлэхэд оршино. <u>Сангийн эрх, үүрэг</u></p>	<p>ЖДҮД Төвийн эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь нийслэл, аймаг, орон нутаг дахь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, ААН-д зөвлөгөө өгөх, сургалт явуулах, мэдээллийн болон инкубацийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх явдал мөн.</p>
<p>Жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр гадаадын бусад улс орнуудын ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллаж хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх</p>	<p>Сангийн өмч, эд хөрөнгийг Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлж эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.</p>	<p>ЖДҮД Төвийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, ААН-д зөвлөгөө өгч, мэдээллээр хангаж, сургалтад хамруулж, тэднийг бие даан бизнес эрхлэх чадвар, мэдлэг эзэмшүүлэхэд оршино.</p>
<p>Хөдөлмөрөөрөө хорших, хөрөнгө хүчээ нэгтгэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт, борлуулалтыг хоршоо, нөхөрлөлөөр дамжуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Сан нь өөрийн хариуцах асуудлаар дотоодын болон гадаад орон олон улсын холбогдох байгууллагуудтай харилцаж хууль тогтоомжид заасан журмаар гэрээ хэлэлцээр байгуулан хамтран ажиллаж хэрэгжилтийг нь хангана.</p>	<p>Жижиг, дунд үйлдвэрт шаардлагатай тоног төхөөрөмж, шинэ технологийн асуудлаар тус салбарын мэргэжлийн холбоод болон эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, мэргэжилтнүүдийг гэрээний нөхцлөөр оролцуулан санал дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулна.</p>
<p><u>Жижиг, дунд үйлдвэрийн газрын үүрэг</u></p>	<p>Жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр дотоодод болон олон улсын хэмжээнд хурал, үзэсгэлэн, уулзалт зохион байгуулж оролцоно.</p>	<p>Иргэний хууль болон бусад хуульд заасан үндэслэл журмыг баримтлан эрх бүхий байгууллагын хууль ёсны шийдвэрээр татан буугдаж, үйл ажиллагаа нь дуусгавар болно.</p>
<p>Жижиг, дунд үйлдвэрийн газар нь Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийг жижиг, дунд үйлдвэр, хоршоотой холбоотой мэдээ, мэдээлэл, бусад материалаар хангах</p>	<p>Жижиг, дунд үйлдвэрийн газар, хоршооны асуудал эрхэлсэн албан хаагчдын нийгмийн асуудлын талаар</p>	<p>Ажлын байр нэмэгдүүлэх талаар төрөөс явуулж буй бодлого, хууль тогтоомж, энэ чиглэлээр тус улсын нэгдсэн</p>

хуульд заасны дагуу дэмжлэг үзүүлэх	бодлого, хууль тогтоомж, хэрэгжилтийн байдалд санал, дүгнэлт гаргах, холбогдох байгууллагуудад санал оруулах,	
Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Жижиг дунд үйлдвэрийн үндэсний зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бүх талын туслалцаа үзүүлэх	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хагас жилийн болон жилийн төсвийн тайланг холбогдох байгууллагуудад гаргаж өгөх,	
Нийслэл, сум, дүүргүүдийн онцлог эрэлт хэрэгцээнд нийцсэн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, хоршоологчдыг дэмжин, орон нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Жижиг, дунд үйлдвэр эрхлэлтийн асуудлаар зөвлөмж гаргах,	
Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, хоршоологчдын зээлийн барьцааны чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тогтолцоог бий болгож, техник технологи, машин, тоног төхөөрөмжийг лизингээр олгох ажлыг зохион байгуулах	Сангийн захирал энэхүү журамд заасан эрх хэмжээний дотор сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллана.	



ЖДҮ-ийг хөгжүүлэх чиглэлээр олгож байгаа зээлийн хэрэгжилтийн тайлан, эргэн төлөлт

д/д	үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2006-2008	2009.12.31	2010.12.31	2009-2010 он Дүн
<u>Орон нутгийн төслийн зээл</u>						
1	ЖДҮХС	сая	2,970.00	18,350.00	15,500.00	33,850.00
2	Эргэн төлөлт	сая		1,000.00	2,447.00	3,447.00
3	Бичил зээлд	сая				
4	Оролцогч банк тоо	тоо	3	6	7	7
5	Оролцооны хувь /20-30/	сая	632.00	6,073.20	4,333.00	10,406.20
6	Орон нутгийн оролцоо	сая	1,850.00	896.00		896.00
7	Бүрдсэн эх үүсвэр	сая	5,452.00	26,319.20	22,280.00	48,599.20
8	Хэрэгжүүлсэн төслийн тоо	тоо	639	1604	1523	3,127.00
9	Зээлийн дүн	сая	6,003.20	25,789.40	22,275.80	48,065.20
10	Өргөжүүлсэн төсөл	тоо		1108	969	2077
11	Шинээр хийсэн төсөл	тоо		496	554	1050
12	Хадгалсан ажлын байр	тоо			4327	4327
13	Шинээр ажлын байр	тоо		5255	3874	9129
14	Шинэ а/б-ны өртөг	мян.төг		4.908	5.750	5.265
	Чиглэл:					
14	Хүнс	хувь		17.0%	25.0%	21.0%
15	МАА	хувь		17.0%	5.0%	11.0%
16	Газар тариалан	хувь		7.0%	19.0%	13.0%
17	Хөнгөн	хувь		25.0%	23.0%	24%
18	Барилга	хувь		5.0%	6.0%	5.5%
19	Ахуй үйлчилгээ	хувь		19.0%	10.0%	14.5%
20	Бусад	хувь		10.0%	12.0%	11.0%
<u>Бүс нутгийн эдийн засгийн хөгжилд нэмэр болох төслийн зээл</u>						
1	ЖДҮХС	сая		12,500.00	12,050.00	24,550.00
2	Эргэн төлөлт	сая			415.9	415.90
3	Оролцогч банк тоо	тоо		8	8	8
4	Оролцооны хувь /20-30/	сая		3,270.00	5,271.10	8,541.10
5	Бүрдсэн эх үүсвэр	сая		15,770.00	17,737.00	33,515.00
6	Хэрэгжүүлсэн төслийн тоо	тоо		34	89	123
7	Зээлийн дүн	сая		12,970.00	17,737.00	30,707.00
8	Өргөжүүлсэн төсөл	тоо		15	62	77
9	Шинээр хийсэн төсөл	тоо		19	27	46
10	Хадгалсан ажлын байр	тоо		766	1995	2761
11	Шинээр ажлын байр	тоо		691	1934	2625
12	Шинэ а/б-ны өртөг	мян.төг		18.770	9.171	11.698
	Чиглэл:					
13	Хүнс	хувь		32%	30.0%	31%
14	МАА	хувь		13%	6.7%	10%
15	Газар тариалан	хувь		21%	16.3%	19%
16	Хөнгөн	хувь		13%	25.0%	19%
17	Барилга	хувь		11%	9.0%	10%
18	Бусад	хувь		11%	13.0%	12%
<u>Лизинг</u>						
1	ЖДҮХС	сая			2,000.00	2,000.00
2	Хамтрагч байгууллага				2	2
3	Оролцоо	сая			2,600.00	2,600.00

4	Бүрдсэн эх үүсвэр	сая			4,600.00	4,600.00
5	Хэрэгжүүлсэн төслийн тоо	тоо			10	10
6	Зээлийн дүн	сая			396.2	396.2
<u>УИХ-ын гишүүдийн багц</u>						
1	УИХ-ын гишүүд багц	сая		1893	730	2623
2	Эргэн төлөлт	сая				
3	Тоо	тоо		6	4	9
4	Бүрдсэн эх үүсвэр	сая		1893	730	2623
5	Хэрэгжүүлсэн төслийн тоо	тоо		28	7	36
6	Зээлийн дүн	сая		1893	200	2093
7	Өргөжүүлсэн төсөл	тоо		19	6	25
8	Шинээр хийсэн төсөл	тоо		9	1	10
9	Хадгалсан ажлын байр	тоо		124	47	171
10	Шинээр ажлын байр	тоо		154	14	168
11	Шинэ а/б-ны өртөг	мян.төг		12.292	14.286	12.458
<u>"Сүү" хөтөлбөр</u>						
1	"Сүү" хөтөлбөр	сая		450	450	900
2	Эргэн төлөлт	сая			35	35
3	Бүрдсэн эх үүсвэр	сая		450	485	935
4	Хэрэгжүүлсэн төслийн тоо	тоо		21	16	37
5	Зээлийн дүн	сая		450	485	935
6	Өргөжүүлсэн төсөл	тоо		9	16	25
7	Шинээр хийсэн төсөл	тоо		12		12
8	Хадгалсан ажлын байр	тоо		73	172	245
9	Шинээр ажлын байр	тоо		120	50	170
10	Шинэ а/б-ны өртөг	мян.төг		3.750	9.700	5.500
<u>ЖДҮХС-ийн эх үүсвэрийн үр дүн:</u>						
1	ЖДҮХС			30,850.00	29,550.00	60,400.00
2	Эргэн төлөлт			1,000.00	2,897.90	3,897.90
3	Банкны оролцоо			9,343.20	12,204.10	21,547.30
4	Орон нутгийн оролцоо			896.00	0.00	896.00
5	Бусад эх үүсвэр			2343	1180	3,523.00
6	Ондоо бүрдсэн эх үүсвэр	сая		44,432.20	45,832.00	90,264.20
7	Олгосон зээлийн хэмжээ	сая		41,102.40	40,697.80	81,800.20
8	Төслийн тоо	тоо		1687	1645	3332
9	Өргөжүүлсэн төсөл	тоо		1151	1053	2204
10	Шинээр хийсэн төсөл	тоо		536	592	1128
11	Хадгалсан ажлын байр	тоо		963	6541	7504
12	Шинээр ажлын байр	тоо		6220	5872	12092
13	Шинэ а/б-ны өртөг	мян.төг		6.608	6.931	6.765
	Төсөл хэрэгжүүлэгч иргэн	хувь		78.6%	79.0%	78.8%
	Төсөл хэрэгжүүлэгч ААН	хувь		21.4%	21.0%	21.2%

Улаанбаатар банкаас бодлогоор олгосон зээлийн судалгаа

(сая төгрөгөөр)

№	ААН-ийн нэр	Зээлийн дүн	Зээлийн үлдэгдлийн дүн	Зээлийн хүү	Зээлийн зориулалт	Зээл авсан огноо	Зээлийн хугацаа	Батлан даалт гаргасан		Зээлийн ангилал				Тайлбар
								Байгууллага	Албан тушаалтан	Хэвийн	Хугацаа хэтрэсэн	Эргэлтэй	Найваргүй	
1	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр	50,0	25,0	12%	Эргэлтийн хөрөнгө авах	2009.09.28	2011.10.13	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	25,0				УБ
2	Уран урсгал ХХК	10,0	9,6	12%	Тоног төхөөрөмж авах	2009.09.30	2011.11.03	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	9,6				
3	Эхлэхүүд ХХК	15,0	15,0	12%	Тоног төхөөрөмж, түүхий эд материал	2009.12.18	2012.02.05	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай				15,0	ЖДҮХС-н эх үүсвэрээр төлөгдсөн
4	Хэнтий Оргил ХХК	40,0	37,9	12%	Эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж	2009.12.17	2011.12.16	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай				37,9	ЖДҮХС-н эх үүсвэрээр төлөгдсөн
5	Баярнэмэх ХХК	50,0	43,7	12%	Тоног төхөөрөмж авах	2009.12.30	2012.06.05	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	43,7				Эргэн төлөлт дутуу
6	Био тус ХХК	50,0	41,7	12%	Лабораторийн тоног төхөөрөмж, түүхий эд авах	2009.12.30	2012.01.11	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай		41,7			
7	Эм Би Би Си ХХК	50,0	32,9	12%	Тоног төхөөрөмж авах	2009.12.30	2012.01.19	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	32,9				
8	Би таньд үнэнч ХХК	13,0	7,4	12%	Эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж	2010.02.04	2012.02.04	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	7,4				
9	Иргэн Дамдинсүрэнгийн Баттөмөр	40,0	17,5	12%	Үхэр, трактор худалдан авах, аж ахуйгаа өргөтгөх	2009.11.05	2011.11.05	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	17,5				
10	Иргэн Пэрэнлэгийн Болд	50,0	36,0	12%	Үнээ худалдан авах, малын сууц барих	2009.12.10	2012.06.08	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	36,0				
	Дүн	368,0	266,7							170,1	43,7		52,9	
	Хувь									64%	16%		20%	

Хас банкнаас бодлогоор олгосон зээлийн судалгаа

(сая төгрөгөөр)

№	ААН-ийн нэр	Зээлийн дүн	Зээлийн үлдэгдлийн дүн	Зээлийн хүү	Зээлийн зориулалт	Зээл авсан огноо	Зээлийн хугацаа	Батлан даалт гаргасан		Зээлийн ангилал				Тайлбар
								Байгууллага	Албан тушаалтан	Хэвийн	Хугацаа хэтрсэн	Срэлээтэй	Найдваргүй	
1	Сүмбэр айраг хоршоо	19,0	10,1	12%	Хүнсний ногоо тариалалт	2009.08.13	2012.05.01	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	10,1				Говьсүмбэр
2	Говь зулганай ХХК	24,0	3,4	12%	Тэмээний ноосон бүтээгдэхүүн	2009.09.15	2012.05.07	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	3,4				Өмнөговь
3	Стандарт мах ХХК	25,0	13,3	12%	Хүнс, бусад үйлдвэрлэл	2009.08.28	2012.09.12	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	13,3				УБ, БЗД
4	Хаан Ембүү ХХК	50,0	50,0	12%	Сүүний үйлдвэрлэл	2009.09.16		ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай			50,0		ЖДҮХС-н эх үүсвэрээр төлөгдсөн, Төв
5	Энхсэржим ХХК	50,0	49,0	12%	Барилгын материал	2009.06.16		ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай			49,0		ЖДҮХС-н эх үүсвэрээр төлөгдсөн, УБ
6	Орлил-контрактшн ХХК	50,0	40,1	12%	Тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах	2009.09.29	2012.09.28	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай				40,1	ЖДҮХС-н эх үүсвэрээр төлөгдсөн, Хэнтий, үндсэн зээл УЛД 37560907.91
7	Иргэн Нарангэрэл Ариунбаяр	6,0	2,9	12%	Малчдын сууцтай чиргүүл үйлдвэрлэх	2009.10.29	2011.10.25	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай				2,9	Хэнтий
8	Иргэн Индэрсүрэн Гантлгмаа	5,0	1,2	12%	"Жавхаа" үсчний салон төсөл	2009.09.09	2011.10.20	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай			1,2		Хэнтий
9	Иргэн Дэрийлаа Эрдэнэжаргал	17,0	8,7	12%	Хими цэвэрлэгээ, үйлчилгээ	2009.09.10	2012.09.03	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай				8,7	Хэнтий
10	Иргэн Гүнчин Чимэддорж	4,5	1,3	12%	Халуун ус, үсчний газар	2009.10.30	2011.11.02	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай			1,3		Хэнтий
11	Иргэн Юндэн Ариунжаргал	10,0	5,3	12%	Цацарганы аж ахуй	2009.09.18	2012.09.25	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай			5,3		Хэнтий
12	Иргэн Найдан Ганхуяг	10,0	5,5	12%	Эсгийний үйлдвэрлэл	2009.10.19	2012.10.18	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай			5,5		Хэнтий
13	Иргэн Монхор Хишигтогтох	20,0	7,1	12%	Маг, махны худалдаа	2009.09.30	2012.05.01	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай			7,1		Говьсүмбэр
14	Иргэн Болбат Баттөмөр	20,0	4,3	12%	Маг, махны худалдаа	2009.09.29	2012.05.01	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагн. -й			4,0		Говьсүмбэр

15	Иргэн Батжаргал Гэрэлтуяа	2.5	0.9	12%	Халуун усны барилга барих	2009.07.21	2012.08.02	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	0.9			Говьсүмбэр
16	Иргэн Ваанчиг Дарьмаа	2.2	1.0	12%	Хивс цэвэрлэгчээ	2009.08.12	2012.08.20	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	1.0			Говьсүмбэр
17	Иргэн Болдсайхан	15.2	8.6	12%	Тоосго үйлдвэрлэл	2009.08.28	2012.08.23	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	8.6			Өмнөговь
18	Иргэн Б.Жаргал- сайхан	34.3	23.3	12%	Цаасан уут үйлдвэрлэл	2009.08.18	2012.08.01	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай		23.3		Баянхонгор, зээлдэгч нас барсан.
19	Иргэн Л.Наранчимэг	40.0	22.3	12%	Үнээний ферм	2009.08.18	2012.08.21	ХХААХҮЯ, ЖДҮХСан	М.Баярмагнай	22.3			Баянхонгор
	Дүн	404,7	258,0							84,0	-	34,9	139,1
	Хувь									33%		14%	54%



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2011 оны 9 сарын 8 өдөр

Дугаар 79

Улаанбаатар

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.”Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зориулалтаар 2010 онд олгосон зээлийн хэрэгжилтийн байдалд”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.


Хоёр.Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав.Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2012 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Ц.Ням-Осор, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирал М.Баярмагнай нарт зөвлөсүгэй.

Тав.Аудитын тайланд тусгагдсан зөрчлийн барагдуулалт, зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

Монгол Улсын Ерөнхий аудиторов
2011 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн
79 дугаар тушаалын хавсралт

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зориулалтаар олгосон
зээлийн хэрэгжилтийн байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн
төлбөр, зөрчлийн жагсаалт

УХА0122

(сая. төг)

Төлбөр, зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
	албан тушаал	нэр		
Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох зориулалтаар авсан бодлогын зээлийг зориулалт бусаар зарцуулж гэрээний үүргээ биелүүлээгүйгээс сангийн хөрөнгөөс суутгасныг ААНБ-уудаас нөхөн төлүүлэх.	ЖДҮХС-ийн захирал Нягтлан бодогч	М.Баярмагнай Л.Лувсан	232.9	-
ЖДҮХС-аас сүүний жижиг үйлдвэр байгуулах зорилгоор авсан зээлийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглаж эмийн худалдаа эрхэлж байгааг нөхөн төлүүлэх	"Хан өндөр" ХХК-ийн захирал	Ц.Өлзийжаргал	30.0	-
Маргарины үйлдвэр байгуулахаар ЖДҮХС-аас авсан зээлээр тоног төхөөрөмжөө бүрэн аваагүй	"Лха түшиг" ХХК-ийн захирал	Ц.Оюунчимэг	-	30.0
ЖДҮХС-аас сүү боловсруулж нийлүүлэх үйлдвэр байгуулахаар авсан ч үйлдвэрлийн техник хэрэгсэл тоног төхөөрөмжийг худалдан авах мөнгө хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар төслийг бүрэн хэрэгжүүлээгүй	"Мон-Лайф" ХХК-ийн захирал	Э. Хосжаргал	-	30.0
ЖДҮХС-аас сүүний ферм байгуулахаар авсан зээлийн хөрөнгийн 41.0 сая төгрөгийг зориулалт бусаар худалдааны бизнест ашиглаж байгаа учир төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийг сангийн дансанд буцаан төлүүлэх.	Хэнтий аймгийн ХХААЖДҮГ-ын дарга "Умардын Од" ХХК-ийн захирал	Б. Цэрэнчимэд Б.Чимэгшүхэр		27.4
Дүн			262.9	87.4